

Боловсролын хамтын ажиллагааны нийгэмлэг

Байгууллагын нэр	Боловсролын хамтын ажиллагааны нийгэмлэг
Байгуулагдсан он	2004 он
Хаяг	Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө 15/1
Утасны дугаар	310663, 318149, 324285
E-mail	info@mea.org.mn
URL/Facebook	www.mea.org.mn
Төлөөлөгчийн нэр	Б.Батжаргал, Гүйцэтгэх захирал
Үйл ажиллагааны товч танилцуулга	<p>Боловсролын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг (БХАН) нь 2004 оны 8-р сард байгуулагдсан Монголын боловсролын салбарт тасралтгүй үйл ажиллагаа явуулж буй төрийн бус байгууллага юм. БХАН-ийн эрхэм зорилго нь Монголын залуу үеийнхэнд хүртээмжтэй, тэгш хамруулсан, чанартай боловсрол олгохын төлөө үр нөлөөтэй түншлэлийг хөгжүүлэн, бодлогод нөлөөлж, боловсролын байгууллага, оролцогч талуудын чадавхыг бэхжүүлэхэд оршино. Энэхүү зорилгын хүрээнд сургууль, багшийн хөгжлийг дэмжих “Нээлттэй сургууль” хөтөлбөр, бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих “Алхам алхмаар” хөтөлбөр, өсвөр үеийнхэн, залуучуудын хөгжлийг дэмжих “Хүүхэд, залуучуудын” хөтөлбөрөөр олон нийтийн оролцоот, тэгш хамруулах үнэт зүйлд суурилан сургууль, цэцэрлэгийн хөгжилд хувь нэмэр оруулах, хүүхэд төвтэй, идэвхтэй арга зүйг түгээн дэлгэрүүлэх, хүүхэд залуучуудын оролцооны болон үзэл бодлоо илэрхийлэх эрхийг дэмжих, бага насны хүүхдийн хөгжилд эцэг эх, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, чанарын судалгаа болон үнэлгээний чиглэлээр үндэсний хэмжээнд үйл ажиллагаа явуулж байна.</p> <p>БХАН нь бага насны хүүхдийн хөгжил, хүүхэд залуучуудын хөгжил, сургууль багшийн хөгжлийг дэмжих гурван үндсэн хөтөлбөр, тэгш хамруулах боловсрол гэсэн чиглэлээр байгуулагдсанаасаа хойш 17 жилийн хугацаанд Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй төрийн өмчийн ерөнхий боловсролын бүх сургуульд хүрч ажилласан. БХАН нь дараах чиглэлээр сургууль цэцэрлэг боловсролын салбарын оролцогч талуудад дэмжлэг үзүүлэн хамтран ажилладаг. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - сургуулийн өмнөх, бага, дунд боловсрол чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, - тэгш хамруулах, олон нийтийн бүтээлч оролцоог нэмэгдүүлэх, сургуулийн менежментийн чиглэлээр сургуулийн хөгжилд дэмжлэг үзүүлэх, - хүүхэд төвтэй, идэвхтэй, шинэлэг арга зүйг түгээн дэлгэрүүлэх, хүүхэдтэй ажиллаж буй багш, сурган хүмүүжүүлэгчдэд сургалтын идэвхтэй болон бүтээлч сэтгэлгээний арга зүйг хүргэх, - эцэг эхийн боловсрол, бага насны хүүхдийн хөгжилд эцэг эхийн оролцоо, эцэг эхээр дамжуулан сургуульд бэлтгэх, - багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийг дэмжих шинэлэг арга зүйг турших, түгээх - хүүхдийн оролцооны болон үзэл бодлоо илэрхийлэх эрхийг дэмжих хичээлээс гадуурх үйл ажиллагааг хөгжүүлэх, - боловсролын хүртээмж, чанар, эрх тэгш байдал, эгэх хариуцлагыг бэхжүүлэхэд тулгарч буй асуудлыг чанарын судалгаагаар илрүүлэн гаргаж боловсролын салбарынхан, олон нийтэд хүргэх, - тэгш хамруулах боловсрол, боловсролын чанар, багшийн мэргэжлийн хөгжил, үр дүнтэй засаглал, баримт нотолгоонд суурилсан, оролцоот бодлогын үйл явцыг хөхиүлэн дэмжих нөлөөллийн ажил өрнүүлэх зэрэг багтана.
Япон болон олон улсын хамтын ажиллагаа	<p>БХАН нь үндэсний болон олон улсын иргэний нийгмийн олон сүлжээнд нэгдэн шинэ санаа, үйл ажиллагаа, агуулга, арга зүйг Монгол Улсад нутагшуулах, өөрсдийн арга туршлагыг бусад оронд түгээн идэвхтэй хамтран ажиллаж байна.</p> <p>Гишүүнчлэл:</p> <ul style="list-style-type: none"> - Олон Улсын Алхам Алхмаар Холбоо/International Step by Step Association – Бага насны хүүхдийн хөгжил, боловсролын чиглэлээр ажилладаг ЕвроАзийн сүлжээ - Боловсролын Бодлогын Төвүүдийн Сүлжээ/Network of Education Policy Centers – Судалгаа, бодлогын нөлөөллийн чиглэлээр ажилладаг Зүүн ба Төв Европ, Төв Ази, Монголыг хамруулсан сүлжээ - Бүтээлчээр Унших Бичих Олон Улсын Консорциум/International Consortium for RWCT – Бүтээлчээр унших, бичих чадварыг хөгжүүлэх - Суурь болон Насанд Хүрэгчдийн Боловсролын Ази, Өмнөд Номхон

	<p>Далайн Нийгэмлэг/Asia South Pacific Association for Basic and Adult Education – Бүс нутагт сурч боловсрох эрх, чанартай боловсрол, насан туршдаа суралцахуй, насанд хүрэгчдийн боловсролын чиглэлээр нөлөөллийн үйл ажиллагааг улс орон, бүс нутаг, дэлхийн хэмжээнд ажилладаг</p> <ul style="list-style-type: none"> - Олон улсын Мэтгэлцээний Боловсролын холбоо/International Debate Education Association - Бага Насны Хүүхдийн Боловсрол, Хөгжлийн төлөөх Төв Ази, Монголын Санаачилга/Central Asia and Mongolia Initiative on Early Childhood Education and Development <p>Мөн 2010 болон 2013 онд БШУЯ, БОНХЯ болон сургууль цэцэрлэгийн төлөөллийг оролцуулсан Японы боловсролын тогтолцоо, цэцэрлэг, сургуультай танилцах аялал (study tour) зохион байгуулсан.</p>
<p>ЖАЙКА-тай хамтарсан төсөл, хөтөлбөр</p>	<p>2006-2009 онд ЖАЙКА-аас хэрэгжүүлсэн “Суралцагчдын суралцахуйг дэмжих арга зүйн хөгжил/Teaching Methods Improvement towards Children’s Development in Mongolia” төслийн хүрээнд</p> <ul style="list-style-type: none"> - Хэрэгцээ тандах судалгаа - Анхны төлөв байдал тогтоох судалгаа - Эцсийн судалгаа <p>2010-2012 онд хэрэгжүүлсэн “Монгол улсад багшлахуйн арга зүйн хөгжлийг түгээн дэлгэрүүлэх тогтолцоог бэхжүүлэх/Project for Strengthening Systems for Improving and Disseminating Child-Centered Teaching Methods in Mongolia” төслийн эцсийн судалгааг хийж гүйцэтгэсэн.</p>



Хайр эрдэм билиг

Байгууллагын нэр	Хайр эрдэм билиг
Байгуулагдсан он	2020 он
Хаяг	Баянгол дүүрэг, 17-р хороо, 76-р байр, 28 тоот
Утасны дугаар	98225566,99022211
E-mail	hayir.erdem.bilge@gmail.com
URL/Facebook	https://www.facebook.com/Hayir-Erdem-Bilig-100765672068381/
Төлөөлөгчийн нэр	М.Салих, Төсөл хариуцсан менежер Х.Ержан
Үйл ажиллагааны товч танилцуулга	<ul style="list-style-type: none"> • Буяны болон хүмүүнэлгийн төслүүдэд чиглүүлэн цуглуулсан орлогын үндсэн дээр материаллаг болон санхүүгийн нөөц бүрдүүлэх, ашиглах, дэмжлэг тусалцаа шаардлагатай ард иргэд болон байгууллагуудад нийлүүлэх • Гадаад дотоодын ард иргэдэд хандив тусламжинд чиглэсэн бара бүтээгдэхүүн болон мал бэлдэх, борлуулах, нийлүүлэх хандивын үзэсгэлэн зохион байгуулах • Онцгой болон онцгой бус тохиолдолд эмзэг бүлгийн ба хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд материаллаг болон санхүүгийн дэмжлэг үзүүлэх • Их дээд сургууль болон ЕБ сургуульд суралцаж буй нийгмийн эмзэг бүлгийн хүүхэд залуучуудад тусалцаа үзүүлж, тэдний үндэсний болон зан заншилын чиглэлээр хүмүүжүүлэхэд дэмжлэг үзүүлэх • Гадаад улсууд болон дотоодод үйл ажиллагаа явуулж байга ижил зорилготой хуулийн этгээдүүдтэй хамтран ажиллах <p>Төсөл боловсруулах, Төрийн болон төрийн бус байгууллагуудын төслийг хэрэгжүүлэх</p>
Япон болон олон улсын хамтын ажиллагаа	БН Турк Улс, Их Британи, Голланд, ХБНГУ
ЖАЙКА-тай хамтарсан төсөл, хөтөлбөр	Байхгүй



Монголын хичээлийн судалгааны нийгэмлэг

Байгууллагын нэр	Монголын хичээлийн судалгааны нийгэмлэг
Байгуулагдсан он	2013 он
Хаяг	Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Багшийн хөгжлийн ордон
Утасны дугаар	94490108, 99231521
E-mail	mals.mongolia@gmail.com
URL/Facebook	Web:mals.mn, FB: Монголын хичээлийн судалгааны нийгэмлэг
Төлөөлөгчийн нэр	Б.Хишигбаяр ,Н.Оюунцэцэг
Үйл ажиллагааны товч танилцуулга	<p>Зорилго: Монгол улсын боловсролд хичээлийн судалгааны арга зүйг судалж хөгжүүлэх замаар хүүхдийг хөгжүүлэх шинэ арга технологийг бий болгох, үндэсний хэмжээнд түгээн дэлгэрүүлэх, багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийг дэмжих, сургуулийн менежментийг дээшлүүлэх замаар боловсролын чанарыг сайжруулах.</p> <p>Үйл ажиллагаа:</p> <ul style="list-style-type: none"> • Хичээлийн судалгааны чиглэлээр сургалт зохион байгуулах, судалгаа хийх • Хүүхэд төвтэй, оролцоонд суурилсан, тэгш хамруулах, дижитал, технологи ашигласан сургалтын шинэ арга зүйг туршин үр дүнг хэлэлцүүлэх, түгээн дэлгэрүүлэх • Хүүхдийн хөгжлийг дэмжсэн багш, эцэг эхчүүдэд зориулсан онлайн платформ хөгжүүлэх, е-контентууд боловсруулах, нээлттэй сан үүсгэх • Багш бэлтгэдэг их, дээд сургууль, ерөнхий боловсролын сургуулийн хамтын ажиллагааг өргөжүүлэх замаар хичээлийн судалгаа, хүүхдийн хөгжлийг дэмжих шинэ арга зүй, технолог бий болгож үндэсний хэмжээнд түгээн дэлгэрүүлэх • Хичээлийн судалгааны арга зүйн танхимын болон онлайн сургалт зохион байгуулах, мониторинг хийх, зөвөлгөө өгөх, сурталчилгаа явуулах, гадаад дотоодын туршлага судлах • Хичээлийн судалгааны арга зүйн чиглэлээр нарийн мэргэжсэн мэргэжилтэн (эксперт, зөвлөх, сурагч багш гэх мэт) бэлтгэх • Хичээлийн судалгааны арга зүйг хөгжүүлэх чиглэлээр гадаад орны хичээлийн судалгааны нийгэмлэгүүдтэй хамтын ажиллагаа, харилцаа холбоог өргөжүүлэх, олон улс (WALS)-ын болон бусад эрдэм шинжилгээний хуралд оролцох, хурал зохион байгуулах, туршлага солилцох • Хичээлийн судалгааны арга зүйн чиглэлээр Япон болон бусад оронд сургалтад хамруулах • Сургууль төвтэй багшийн мэргэжил дээшлүүлэх үйл ажиллагааг хөгжүүлэх, сургуулийн менежментийг сайжруулах • Боловсролын яамны харъяа Багшийн мэргэжил дээшлүүлэх институттэй хамтран эрдэм шинжилгээний бага хурлыг жил бүр зохион байгуулах
Япон болон олон улсын хамтын ажиллагаа	<p>Японы их дээд сургуулиудын /Токуо Gakugei, Saitama, Okayama/ профессороос зөвлөгөө авах, ерөнхий боловсролын сургуулиудаар /Inagi, Aoyama, Seinan, Saitama, Minato, Osaka, Kyoto/ зочлох, туршлага судлах чиглэлээр 2014 оноос хойш жил бүр /7 жилд 100 гаруй багш, захирал/ Японд мэргэжил дээшлүүлсэн.</p> <p>WALS- World Association of Lesson Study зохион байгуулдаг олон улсын эрдэм шинжилгээний хуралд МХСН-ээс 2015 -2019 онуудад оролцож илтгэл тавьсан.</p>
ЖАЙКА-тай хамтарсан төсөл, хөтөлбөр	<p>JICA/ ЖАЙКА Олон улсын байгууллага, Боловсролын шинжлэх ухааны яамтай хамтран хэрэгжүүлсэн</p> <ol style="list-style-type: none"> 1) “Хүүхдийн хөгжлийн дэмжих багшлах арга зүйг дэмжих”, 2006-2010; 2) “Багшлахуйн арга зүйг түгээн дэлгэрүүлэх тогтолцоог бэхжүүлэх” 2010-2013 төсөл хэрэгжиж дуусаад <p>2013 оны 8 дугаар сарын 31-ны өдөр эдгээр төслүүд дээр ажиллаж байсан их дээд сургууль, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн байгууллагын төлөөллүүд санаачлан тус нийгэмлэгийг байгуулсан. Нийгэмлэгийг ЖАЙКА-аас хэрэгжүүлсэн төслийн тогтвортой байдлыг хангах, Монголд хичээлийн судалгааг үндэсний хэмжээнд түгээн дэлгэрүүлэх замаар сургалтын чанарыг сайжруулах зорилгоор байгуулсан.</p> <p>Монголын хичээлийн судалгааны нийгэмлэгийн гишүүд ЖАЙКА-аас зохион байгуулдаг мэргэжил дээшлүүлэх хөтөлбөрт 2015-2019 хамрагдаж байсан.</p>



Зорилго: Япон багш нарын арга зүйгээс суралцах

Нийт оролцогч 16. Үүнээс:

- ❖ БМДИ-ийн арга зүйч- 10
- ❖ БСГ-ын дарга- 2
- ❖ БСГ-ын мэргэжилтэн- 1
- ❖ ЕБС-ийн захирал-1
- ❖ ЕБС-ийн багш- 2



New Tab x Хичээлийн судалгааны нийгэмлэг mals.mn

Хайх утгаа оруулна уу ...

МОНГОЛЫН ХИЧЭЭЛИЙН СУДАЛГААНЫ НИЙГЭМЛЭГ
MONGOLIAN ASSOCIATION OF LESSON STUDY

НҮҮР | БИДНИЙ ТУХАЙ | СУРГАЛТ | ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ | ЗӨВЛӨГӨӨ | СУДАЛГААТ ХИЧЭЭЛ | ГАДААД ХАРИЛЦАА

“ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖСЭН БАГШЛАХ АРГА ЗҮЙ- 2015” СЭДЭВТ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ГУРАВДУГААР БАГА ХУРАЛ АМЖИЛТТАЙ БОЛЖ ӨНГӨРЛӨӨ

Иргэний боловсролын төв

Байгууллагын нэр	Иргэний боловсролын төв
Байгуулагдсан он	1992 он
Хаяг	Чингэлтэй дүүрэг, MN Tower (Тэнгис кинотеатрын урд талд), 15 давхар, 1505 тоот
Утасны дугаар	99117383
E-mail	narangerelrinchin37@gmail.com
URL/Facebook	https://www.facebook.com/cce.mongolia
Төлөөлөгчийн нэр	Ринчиний Нарангэрэл
Үйл ажиллагааны товч танилцуулга	<ol style="list-style-type: none"> 1. ЕБС-ийн багш, сурагчид; хот, хөдөөгийн залуучууд, ард иргэд, төрийн албан хаагчдад ардчиллын боловсролыг түгээх олон төрлийн сургалт, төсөл хэрэгжүүлдэг. 2. Хүүхэд залуучуудыг экологийн боловсролоор дамжуулан байгаль орчноо хайрлан хамгаалах дадал, зуршилтай болгоход чиглэгдсэн үйл ажиллагаа явуулдаг. 3. АНУ-ОХУ-Монголын байгаль хамгаалагчдын солилцооны хөтөлбөр хэрэгжүүлсэн. 4. Багш нарын мэргэжил дээшлүүлэх, заах арга барилыг нь сайжруулах сургалт, семинар зохион байгуулж ном, гарын авлага хэвлэн нийтэлдэг. 5. Орон нутгийн өөрийн удирдлагын байгууллага – Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч нарт иргэдийн оролцоотойгоор орон нутгаа хөгжүүлэх арга барил танилцуулах семинар зохион байгуулдаг. 6. НҮБ-ын Хүн Амын Сантай хамтарж “Залуучуудын Хөгжлийн Хөтөлбөр”-ийг Улаанбаатар хот, 11 аймаг, 3 сумд хэрэгжүүлсэн. 7. НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн дэмжлэгээр “Иргэний Боловсролоор дамжуулан залуучуудыг хөгжүүлэх” төслийг хэрэгжүүлсэн. 8. АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлагийн санхүүжилтээр LEAD хөтөлбөр, Иргэн төслийг орон даяар хэрэгжүүлсэн. 9. “Бүгд Залуусын төлөө, Залуус Бүгдийн төлөө” төслийг Европын Холбооны Санхүүжилтээр Каритас Чех Републик, Монголын Залуучуудын Эвсэлтэй хамтран хэрэгжүүлж байна.
Япон болон олон улсын хамтын ажиллагаа	<p>Япон улсын UI-ZENSEN Үйлдвэрчний байгууллагатай хамтран Сэлэнгэ аймгийн Ерөө сумын иргэдийн Ардын Элч ТББ-тай олон жилийн түншийн харилцаатай байж, жил бүр UI-ZENSEN-ны сайн дурынхныг урьж ажиллуулж байсан.</p> <p>АНУ-ын Багш нарын холбоо, Center for Civic Education, Russell Sage College, Польш Улсын Ардчиллын төлөө Боловсролын Сан, олон улсын CIVITAS International зэрэг байгууллагуудтай олон жилийн турш хамтран ажилласан.</p>
ЖАЙКА-тай хамтарсан төсөл, хөтөлбөр	Байхгүй



Сайн боловсролын төлөө

Байгууллагын нэр	Сайн боловсролын төлөө
Байгуулагдсан он	2015 он
Хаяг	Баянгол дүүрэг, 4-р хороо, 2-р хороолол, 6-4 тоот
Утасны дугаар	99192023
E-mail	For_better_education@yahoo.com
URL/Facebook	https://www.facebook.com/forbetteredu
Төлөөлөгчийн нэр	Д.Номинчимэг
Үйл ажиллагааны товч танилцуулга	Ахлах сургуулийн ангийн сурагчдад мэргэжил сонгох талаар зөвлөгөө өгөх. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн үйлчилгээг сайжруулах. Өсвөр насны охид хөвгүүдэд зөвлөгөө өгөх. Хөдөө орон нутаг дахь хүүхэд залуучуудын тэгш боловсролд дэмжлэг үзүүлэх.
Япон болон олон улсын хамтын ажиллагаа	Канадын сан АНУ-ын ЭСЯ, АНУ-ын Төрийн департамент
ЖАЙКА-тай хамтарсан төсөл, хөтөлбөр	Байхгүй



Бүх нийт боловсролын төлөө

Байгууллагын нэр	“Бүх нийт боловсролын төлөө!” Иргэний нийгмийн үндэсний эвсэл
Байгуулагдсан он	2010 он
Хаяг	Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Элчингийн гудамж, Шүрэн барилга 3 давхар, 1 тоот
Утасны дугаар	70008292
E-mail	info@all4education.mn
URL/Facebook	https://www.facebook.com/AFEMNG
Төлөөлөгчийн нэр	Ерөнхий зохицуулагч Д.Тунгалаг
Үйл ажиллагааны товч танилцуулга	<p>Эвслийн танилцуулга:</p> <p>Боловсролын чанар, санхүүжилтэд хяналт тавьж, уг салбарын хариуцлагын тогтолцоог иргэдийн оролцоотойгоор сайжруулах чиглэлээр боловсролын бодлогод нөлөөлөн хамтран ажиллах, үндэсний хэмжээнд үйл ажиллагаа явуулахаар иргэний нийгмийн олон талын төлөөлөл бүхий эвслийг 2010 оны 9-р сарын 3-ны өдөр байгуулж, үйл ажиллагаагаа явуулж байна.</p> <p>Эвсэл нь хүний эрхийн байгууллагууд, эмэгтэйчүүдийн болон хүүхдийн эрхийн төрийн бус байгууллага (ТББ), хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ТББ, хүүхэд, залуусын өөрийн удирдлагын бүлгүүд, үйлдвэрчний эвлэл, үндэсний болон бэлгийн цөөнхийн ТББ, хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах ТББ, боловсролын асуудлаар ажилладаг ТББ зэрэг иргэний нийгмийн 34 байгууллагыг эгнээндээ нэгтгэн ажилладаг. 2 дүүрэг, 6 аймагт салбар зөвлөлтэй үндэсний хэмжээний иргэний нийгмийн байгууллага юм.</p> <p>Эвслийн алсын хараа</p> <p>“Хүүхэд, насанд хүрэгч бүрт хүртээмжтэй; хүний эрх, жендэрийн тэгш эрхэд суурилсан; үнэт зүйл, мэдлэг, ур чадвар хосолсон цогц чадамжийг өөртөө тохиромжтойгоор, аливаа ялгаварлан гадуурхалтгүйгээр амьдралын бүх хүрээнд, насан туршдаа эзэмших боломжтой; эрүүл, аюулгүй орчин бүрдсэн; ялгаатай хэрэгцээг харгалзсан; хүмүүнлэг, ардчилсан; бүх нийтийн; ил тод, хариуцлагатай; хангалттай санхүүжилттэй; иргэдийн оролцоо бүхий боловсролын тогтолцоо” байна.</p> <p>Эрхэм зорилго:</p> <p>Иргэний нийгмийн олон салбар, нийгмийн олонлог төлөөллийг, ялангуяа үндэсний, хэлний, бэлгийн цөөнх; эмэгтэйчүүд, хүүхдүүд, залуус, ахмад үеийнхэн; хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд, иргэд, хөдөө орон нутаг, гэр хорооллын иргэд зэрэг дуу хоолойгоо олон нийт, төр, засагт хүргэж, шийдвэр гаргахад оролцож чадахгүй байгаа бүлгүүдийг чадваржуулах, харилцаа, хамтын ажиллагааны орон зайг бий болгох замаар тэдэнд тулгарч буй бэрхшээлийг арилгах, нөхцөл байдлыг өөрчлөх чадвартай болгон, эрх мэдлийг нь нэмэгдүүлж, боловсролын бодлого, тогтолцоог цогцоор нь шинэчлэхэд оршино.</p> <p>Эвслийн уриа:</p> <p>Боловсролыг бүх нийтэд – Бүх нийт боловсролын төлөө!</p> <p>Боловсрол эвсэл 2020-2023 онд Боловсролын төлөөх дэлхийн түншлэл сангийн санхүүжилттэй “Боловсролын төлөө чанга дуугарцгаая!” төслийг үндэсний хэмжээнд хэрэгжүүлж байна.</p>
Япон болон олон улсын хамтын ажиллагаа	ASPBAE (Суурь болон насанд хүрэгчдийн насан туршийн боловсролын нийгэмлэг)-ийн гишүүн GCE (Global Campaign for Education)-ийн гишүүн
ЖАЙКА-тай хамтарсан төсөл, хөтөлбөр	Байхгүй

Уншигч хөтөлбөр

Байгууллагын нэр	Уншигч хөтөлбөр НҮТББ (Reader NGO)
Байгуулагдсан он	2021 он
Хаяг	Сүхбаатар дүүрэг, Амарын гудамж-2, Адмон принт компанийн байр
Утасны дугаар	95014450, 99223375
E-mail	info@readerngo.com
URL/Facebook	Reader NGO
Төлөөлөгчийн нэр	Э.Цэнгэлсайхан
Үйл ажиллагааны товч танилцуулга	<p>Манай гол үйл ажиллагаа нь “Сургуулийн номын сан” хэмээх төсөл бөгөөд энэхүү төслөө одоогоор Нийслэлийн ЕБС 28 дугаар сургууль дээр хэрэгжүүлж байна. Төслийн зорилго нь сурагчдын унших хүсэл сонирхлыг өдөөж, ном унших дадал хэвшүүлэх, багш ажилчдыг хүүхдийн номтой ажиллаж сургах билээ. Бид энэхүү туршлагаа жишиг болгон ашиглаж цаашид олон сургуульд төслөө хэрэгжүүлэх зорилготой. Төслийн үйл ажиллагаа үндсэн дөрвөн чиглэлтэй.</p> <ul style="list-style-type: none"> • Цаасан болон цахим номын хүртээмжийг нэмэгдүүлэх • Номын сангийн орчинг сайжруулах • Номын сангийн программыг сайжруулах • Багш ажилчдад сургалт хөгжүүлэлт хийх <p>Төсөл маань 3 жил үргэлжлэх ба эхний жил бага бүлэгт, дараагийн жил дунд бүлэгт, сүүлийн жил ахлах бүлгийн багш, сурагчдад төвлөрнө. Одоогоор сургуулийн бага бүлгийн анги тус бүрд зөөврийн номын тавиур, хүүхдийн насны онцлогт тохирсон олон төрлийн ном хүлээлгэн өгөөд байна. Мөн сурагчдыг идэвхжүүлэх үйл ажиллагаа, бүтээлч аянуудыг сургуультай хамтран зохион байгуулж байна (өдрийн тэмдэглэл бичих, сургуулийн газрын зураг бүтээх гэх мэт). Түүнчлэн төслийн зөвлөх, гаднын экспертүүд маань сургуулийн багш нартай тогтмол сургалт хийдэг. Үүнээс гадна номын сонголт, сургалт, семинартаа бид Монсудар хэвлэлийн компанитай хамтран ажилладаг билээ. Мөн цаашид багш нарт хүүхдийн номыг бүтээлчээр ашиглах талаар гарын авлага орчуулан гаргаж, түүгээрээ сургалт орохоор бэлдэж байна. Төслийн дэлгэрэнгүй танилцуулгатай доорх линкээр орж танилцана уу:</p>
Япон болон олон улсын хамтын ажиллагаа	UNICEF бидний үйл ажиллагааг дэмжиж бага бүлгийн үйл ажиллагаанд ашиглах тодорхой санхүүжилт олгосон.
ЖАЙКА-тай хамтарсан төсөл, хөтөлбөр	Одоогоор байхгүй.



Япон улсын заах арга барилын талаар багш, ажилчидтай цуврал семинар хийж байна.



Өдрийн тэмдэглэлийн аянд зориулж ангиудаар танилцуулга хийв.



Сургуульд номоо хүлээлгэн өгч, төслийн нээлт хийх үед зочид номтой танилцаж байна.



Сурагчид номоо уншиж байгаа нь.

Боловсролын реформ хөдөлгөөн

Байгууллагын нэр	Боловсролын реформ хөдөлгөөн
Байгуулагдсан он	2019 он
Хаяг	Сүхбаатар дүүрэг, 2-р хороо, Meru tower, 1402 тоот
Утасны дугаар	88884224
E-mail	edureformngo@gmail.com
URL/Facebook	FB: Боловсролын реформ хөдөлгөөн /https://www.facebook.com/psychologybasededucation/
Төлөөлөгчийн нэр	Ө.Ганзориг
Үйл ажиллагааны товч танилцуулга	<p>Тус төрийн бус байгууллага нь монгол улсын боловсролын чанарыг сайжруулах чиглэлээр ажиллаж буй тэргүүлэх олон нийтийн байгууллага юм. Бид улс төр, төрийн бодлогын лобби хийх, олон нийтийг үнэн зөв мэдээллээр хангах, эцэг эхчүүдийг боловсролын реформын үйл хэрэгт татан оролцуулах талаар өргөн хүрээтэй ажиллаж байна. Тус байгууллагын сошиал хуудсыг 50 гаруй мянган эцэг эчүүд дагаж байна. Бид өнгөрсөн хугацаанд нийтдээ 5,000 гаруй эцэг эхчүүдэд төрөл бүрийн хурал, семинар, онлайн уулзалт зохион байгуулж ажилласан. Мөн УИХ-н гишүүд, бодлого гаргагч нар, эрдэмтэн мэргэдийг оролцуулсан олон тооны хэлэлцүүлгийг зохион байгуулав. Манай байгууллагаас гаргасан зөвлөмжийн дагуу боловсролын тухай шинэ хуулийн төсөлд бодитой санал өөрчлөлтүүд тусгагдаж байна. Зорилго: Монгол хүнийг дэлхийд өрсөлдөхүйц боловсролтой хүн болгох зорилгын хүрээнд дараах 6 стратегит тулгуурласан үйл ажиллагаа явуулна.</p> <ol style="list-style-type: none"> 1. Эрүүл бус улс төр нь боловсролын салбарыг бүхэлд нь сулруулж тогтворгүй, үр дүнгүй, уялдаагүй, засаглалын хямралтай тогтолцоог бий болгож байгаа учир боловсролын салбарыг улс төрөөс ангид байлгах стратегийг нэн тэргүүнд барьж ажиллана 2. Боловсрол өнөөдөр зөвхөн шинжлэх ухааны мэдлэг, чадвар IQ-гээр өрсөлдөх тухай биш, сэтгэлээ удирдах, дасан зохицох, манлайлах, багаар ажиллах, асуудал шийдэх, тунгаан цэгнэх, шинийг санаачлах, насан туршдаа суралцах, бусдыг хүндэтгэх, үнэнч шударга, тууштай, хариуцлагатай, байгаль орчин-тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулагч цогц чадамжтай хүнийг хөгжүүлэх өргөн хүрээнд чиглэж байгаа учраас бид үнэт зүйлд тулгуурласан, суралцагч төвтэй, сэтгэл зүйд суурилсан боловсролыг хөгжүүлэх нь реформын чухал цөм юм; 3. Боловсролын реформын гуравдагч стратеги нь дижитал суурьтай боловсрол байх юм. Хүн бүр чанартай боловсрол олж авах орчин бий болгож, сурах арга барилыг технологийн давуу талыг ашиглан хэрэгжүүлнэ. Аж үйлдвэрийн 4-р хувьсгалын дүнд автоматжуулалт, дижиталжилт, хиймэл оюун ухаан, юмсын интернет гэхчлэн технологийн дэвшлээр ирээдүйн ажлын байр эрс өөрчлөгдөж байгаатай уялдуулан дижитал эринд бэлтгэгдсэн ирээдүйн ажиллах хүчийг бэлтгэхэд чиглэнэ; 4. Тооноос чанарт шилжих биш, тоо бүрийг чанар болгон хувиргах стратеги: Монгол шиг цөөхөн хүн амтай улсад хүүхэд бүрийг орхилгүй хөгжүүлж, дэлхийд өрсөлдөхүйц хүн болгоход чиглэгдэнэ; 5. Боловсролын реформыг хэрэгжүүлэгч гол хүч нь багш нар бөгөөд багшийн нэр хүнд, ур чадвар, итгэл үнэмшлийг дээшлүүлж, эрдэмд хөтөлсөн багшийг эх мэт хүндэтгэх Монголын уламжлалт үнэт зүйлийг сэргээн багшийн боловсролыг, багшийн хөдөлмөрийг төгөлдөржүүлнэ; 6. Боловсролын реформ нь хүүхэд, багш төдийгүй эцэг, эх олон нийтийг түшиглэнэ. Нэгэнт хүүхдийн сэтгэлзүйн төлөвшил нь хожмоо түүний аз жаргал, эдийн засгийн бүтээмжид нөлөөлдөг нь нотлогдсон бөгөөд сэтгэлзүйн зарим тохиолдолд 70 хүртэлх хувь 2 хүртэлх насанд төлөвшиж байгаа нь судлагаагаар гарч ирж буй тул эцэг эхчүүдийг бэлтгэх нь тус боловсролын реформын чухал бүрэлдэхүүн хэсэг юм. <p>Үйл ажиллагааны чиглэл болон хийсэн ажлууд: Судалгаа: Монголын нийгмийн үеийг тодорхойлох судалгаа, Хүүхдийн хоцрогдол судлах судалгаа, Боловсролын бенчмарк судалгаа, Хүүхдийн хөгжлийн судалгаа, Багшлах арга зүйн судалгаа, Эцэг эх, гэр бүлийн судалгаа, Нийгмийн хөгжлийн судалгаа. Сургалт, сурталчилгаа: Хүүхдэд зориулсан эрсдэлийн сургалт. Нийтлэл: Кэмбрижийн хөтөлбөрөөр явах уу? Үндэсний сургалтын хөтөлбөрөө</p>

	<p>сайжруулах уу?, Профессорын хүүхэд л профессор, сайдын хүүхэд л сайд болдог нийгмийг бид хүссэн үү?, Их сургуулийн бие даасан байдлыг дархал, Хиймэл оюун ухаан багшийг орлох уу?, Багшийн хүлээлт хүүхдийг тодорхойлдог, Хүүхдийг эргэлзэж сургах тал дээр, Өөрөө бие даан хийх нь суралцах хамгийн үр дүнтэй арга юм, Цээжлэлт дээр суурилсан систем буруу, Түүхийн хичээлийг хэрхэн заах ёстой вэ?, Улаанбаатарын боловсролын байгууллагуудын тэгш бус хүртээмж.</p> <p>ТВ нэвтрүүлэг: Үнэ цэнийн эрэлд- хэлэлцүүлэг. Форум, хэлэлцүүлэг: Боловсролын форум яагаад хэрэгтэй вэ?, Боловсролын реформд Цахим боловсрол, Боловсролын эрх зүйн шинэчлэл – цуврал хэлэлцүүлэг, Боловсролын ерөнхий хууль, Дээд боловсролын шинэчлэл, Монголын боловсролын зорилго, Цахим боловсрол ба тэгш боломж, Цахим боловсрол, Виртуал реалити технологиор дамжуулан идэвхтэй суралцахуйг дэмжих нь, Цахим шийдлээр боловсролын тэгш бус байдлыг бууруулах боломж, Хүүхдийн сэтгэлзүй, Боловсролын чанар, тэгш хүртээмж, Сурлагын амжилт, үнэлгээ, Төгсөгчийн бүтээмж, КОВИД цар тахлын үеийн тулгамдсан асуудал, Олон улсын вебинар, хэлэлцүүлэг – Дээд боловсролын реформ</p>
Япон болон олон улсын хамтын ажиллагаа	Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр Боловсрол, шинжлэх ухааны яамны “Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын хоцрогдлыг нөхөх, арилгах цогц төлөвлөгөө” боловсруулах ажлын хэсэг
ЖАЙКА-тай хамтарсан төсөл, хөтөлбөр	Байхгүй

Монж-Шанд

Байгууллагын нэр	Монж-Шанд
Байгуулагдсан он	2021 он
Хаяг	Хан-Уул дүүрэг, 20-р хороо, 45-103 тоот
Утасны дугаар	88689269, 99887172
E-mail	Monjishand@gmail.com
URL/Facebook	https://www.facebook.com/Monji-Shand-105341641820487
Төлөөлөгчийн нэр	Сато Кэийчи
Үйл ажиллагааны товч танилцуулга	<p>Манай Монжи-Шанд ТББ нь 2021 оны 7-р сард үүсгэн байгуулагдсан бөгөөд үүсгэн байгуулагчаар Сато Кэийчи ажиллаж байна. Манай ТББ нь дараах ерөнхий хоёр чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Манай ТББ нь нэг хичээлийн танхимтай бөгөөд бүх хүүхдэд нээлттэй байдгаараа онцлогтой. Зарим улсын болон хувийн сургуульд Япон хэлний багш болон сургалтын хөтөлбөр байдаггүй учир Япон хэл сурах хүсэлтэй хүүхдүүдэд Сато Кэийчи багш хичээлийн хөтөлбөр боловсруулан заадаг. Үүнээс гадна Монголд байдаг бусад Япон хэл заадаг сургалтын төвүүдийн багш нарт Япон хэл заах арга зүйн талаар хичээл ордог. Гол зорилго нь Монголд байгаа Япон хэл суралцаж буй хүүхдүүдийн сурах арга барилыг сайжруулах, Япон хэл зааж байгаа багш нарын заах арга зүйг сайжруулан чанаржуулахад оршино. 2. Үүсгэн байгуулагч Сато Кэийчи нь 2017 оноос хойш Монголд Бейсбол /Тийбол/зааж байгаа бөгөөд шалтгаан нь өвлийн улиралд хүүхдүүдэд хичээл заах явцад хүүхдүүд маш их ханиад томуу тусч байсан нь дасгал хөдөлгөөн хангалттай хийж чаддаггүй байдгаас харагдаж байсан. Одоогийн байдлаар бид Монголын Тийболын Үндэсний холбоотой хамтран ажиллаж Тийбол гэх шинэ спортын төрлийг Монгол орон даяар түгээн дэлгэрүүлэхэд шамдан ажиллаж байна. Тийбол нь Бэйсболын нэг төрөл бөгөөд энэ спортоор хичээллэхэд тийм ч олон төрлийн хэрэгсэл хэрэггүй байдгаараа онцлогтой. Тийболын бөмбөг нь маш зөөлхөн материалаар хийгдсэн байдаг ба цохиур нь резинэн материалаар хийгдсэн байдаг. Ийм учраас энэ спорт нь зөвхөн хүүхдэд гэлтгүй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд болон өндөр настнууд, эрэгтэй эмэгтэй хүүхдүүд , гадаад иргэд гээд хүссэн хүн болгон аз жаргалтайгаар тоглох боломжтой байдаг. Уг спортоор дамжуулан гурван төрлийн ойлголт өгөх зорилготой ба үүнд: <ul style="list-style-type: none"> ● Баг, хамтын ажиллагааны үнэ цэнийг ойлгох ● Хүүхэд өөрийн тогтмол хүрээллээс гаран хөгжлийн бэрхшээлтэй, өндөр настай бусад орны гэх мэт янз бүрийн хүмүүстэй эрх тэгш харилцаж сурах чухал чадварыг эзэмшинэ. ● Уг спортоор дамжуулан бие бялдрын болоод оюун ухааны хөгжлийг зэрэг олгох юм. <p>Бид долоо хоног бүрийн Бямба, Ням гарагт Тийболын бэлтгэл орж ажлын таван өдрийн хоёрт нь Япон хэлний хичээл орж байна.</p>
Япон болон олон улсын хамтын ажиллагаа	Одоогоор байхгүй
ЖАЙКА-тай хамтарсан төсөл, хөтөлбөр	Одоогоор байхгүй



Толгойт хорооллын нутгийн хөгжлийн төв

Байгууллагын нэр	Толгойт хорооллын нутгийн хөгжилийн төв
Байгуулагдсан он	2004 он
Хаяг	Сонгино хайрхан дүүрэг, 3-р хороо, Бага нарангийн 43-р гудамж 4 тоот
Утасны дугаар	99182317, 99832121
E-mail	tolgoit@tcdc.mn
URL/Facebook	Вэб хуудас: www.tcdc.mn
Төлөөлөгчийн нэр	Т.Амгалан- Удирдах зөвлөлийн гишүүн М.Дөлгөөн- Хөтөлбөрийн захирал О.Золзаяа- Орон нутгийн зохицуулагч
Үйл ажиллагааны товч танилцуулга	<p>Толгойт хорооллын Нутгийн хөгжлийн төв нь 2004 оны 9 сард байгуулагдсан ашгийн бус, нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага юм.</p> <p>Бидний эрхэм зорилго Толгойт хороололд амьдарч буй иргэдийн санаачлага, хэрэгцээнд тулгуурлан орон нутгийн хөгжил дэх иргэдийн оролцоог дэмжих, нутгийн байгууллагуудын түншлэлийг хөгжүүлэх, орон нутгийн засаглалын чадавхийг бэхжүүлэхэд оршдог.</p> <p>Эрхэм зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> ◆ Орон нутгийн хөгжилд иргэдийн оролцоог дэмжих замаар нутгийн өөрөө удирдах ухаалаг засаглалыг хөгжүүлэх ◆ Иргэдийн сайн дурын бүлгүүдийн дэмжлэгтэйгээр байгаль орчинд ээлтэй орон нутгийг төлөвлөн чадавхижуулах ◆ Иргэдийн нийгмийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх ◆ Хүнд нөхцөл амьдарч буй хүүхэд, тэдний гэр бүлд хүмүүнлэгийн тусламж үзүүлэх <p>Дээрх зорилтуудаа Нийгмийн эрүүл мэндийн боловсрол, Нутгийн өөрөө удирдах ухаалаг засаглал, Ногоон хороо, Хүүхэд хамгаалал гэсэн дөрвөн хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлдэг.</p> <p>Жил бүр ажилд уриалдаг.</p>
Япон болон олон улсын хамтын ажиллагаа	<p>Япон улсын Шига мужийн Оцү хотын “Кэйжи-Монголын иргэдийн нөхөрсөг харилцааны нэворк”-той хамтран 2018 оны 3 сараас айл өрхөөс гарч буй хүнсний хог хаягдлаар бордоо хийх санаачлага маань 4 дэх жилдээ үргэлжлэн хийгдэж байна. Бидний энэхүү ажил нь нэг газар амьдарч буй хүмүүст өөрсдийнх нь оролцоотой илүү сайхан орон нутгийг хөгжүүлэхэд туслаж байгаагаараа чухал ач холбогдолтой үйл ажиллагаа юм. Энэхүү санаачлагын хүрээнд “Толгойт дахь хүнсний хаягдалд дахин боловсруулах сүлжээ” байгуулагдан ажиллаж байна.</p> <p>Сүлжээний үйл ажиллагааг өрхийн бизнес, орон нутгийн иргэдийн хамтын хоршооллыг үүсгэхийн төлөөх үйл ажиллагаанд чиглүүлж байгаа бөгөөд өрхийн түвшинд хүнсний ногоо тариулан эрхэлдэг 5 өрхийг түшиглэн хүнсний ногоо тариалах, хүнсний хаягдлаар бордоо хийх, хөршүүддээ сурталчлах манлайлах “Түшиц өрх” байгуулан, тэдний хамтын ажиллагааг идэвхижүүлэн, чадавхижуулах ажлыг зохион байгуулж байна. “Кэйжи-Монголын иргэдийн нөхөрсөг харилцааны нэворк”-ын дэмжлэгтэй манай төвийн 2 хүн Японд хүнсний хаягдлаар бордоо хийх дадлагажих сургалтанд 2019 онд хамрагдсан. 2010 оноос өнөөг хүртэл Дүфрэнэ Готьерын Сан (FDG)-тай хамтран “Толгойт хорооллын эмзэг бүлгийн хүүхдүүд, тэдний гэр бүлд дэмжлэг үзүүлэх нь” төслийг хэрэгжүүлж байна. Уг төсөл нь төвийн хүүхдийн хөгжил, хамгааллын хөтөлбөрийн үйл ажиллагааг дэмжлэг бөгөөд жил бүр хөгжлийн бэрхшээлтэй сургуульд сурч чадахгүй байгаа хүүхдүүдэд зориулсан “Гэрийн сургалт”, сургуулийн зуны амралтын үеэр гэртээ дүү нараа асрах үүрэгтэй үлддэг тусламж хэрэгтэй хүүхдүүдэд зориулсан “Хүүхдийн өдрийн зуслан”-гийн үйл ажиллагааг санхүүжүүлдэг.</p> <p>Орон нутгийн хөтөлбөрийн зохицуулагч О.Золзаяа 2019 оны 1-р сард SAORI International Volunteer College-ийн урилгаар SAORI олон улсын сургагч багш бэлтгэх сургалтанд хамрагдсан. SAORI-гийн сургалтыг ХБХ, тэдний эцэг эх, хүүхдийн эко бүлгийн сонирхсон хүүхдүүдийн хүрээнд явуулж ирсэн.</p>
ЖАЙКА-тай хамтарсан төсөл, хөтөлбөр	<p>2013-2015 онуудад ЖАЙКА-ийн сайн дурын ажилтан хүлээн авах хөтөлбөрт хамрагдаж сайн дурын ажилтан Вашиминэ Мотое-той хамтран ажилласан.</p> <p>ЖАЙКА-ийн дэмжлэгтэйгээр “Сонгосон орон нутгийн хүнсний хэрэглээ, шим тэжээлийн нөхцлийг сайжруулах” төслийг (“Food consumption patterns and</p>

nutritional balance”) 2020 онд хэрэгжүүлсэн. Бид Сонгино Хайрхан дүүрэг (СХД)-ийн Толгойт бүсийн 1, 3, 4, 26, 35, 36-р хорооны сонгосон 96 өрхийн хүнсний хэрэглээ, шим тэжээлийн нөхцөл байдлыг судлахын хамтраар КОВИД-19 цар тахалын үр нөлөөнөөс үүдэн эмзэг бүлгийн өрхийн гишүүд, ялангуяа хүүхдүүд хүнс тэжээлийн дутагдалд өртөхөөс сэргийлэх зорилгоор зорилтот өрхийн 612 гишүүнд хоол, хүнс хүргэх богино хугацааны төслийг 2020 оны 7-р сарын 7-ноос 9-р сарын 18 хүртэлх 11 долоо хоногт хийж гүйцэтгэсэн. Энэхүү богино хугацааны төслийн зорилго нь i) “Хөдөө аж ахуйн салбарын нэмүү өртгийн мастер төлөвлөгөө боловсруулах туршилтын төсөл”-д хувь нэмэр оруулах, ii) КОВИД-19 цар тахалын үр нөлөөнөөс үүдэн эмзэг бүлгийн өрхийн гишүүд, ялангуяа хүүхдүүд хүнс тэжээлийн дутагдалд өртөхөөс сэргийлэх, iii) Хоол, хүнс хүлээн авсан өрхүүдийн хүнсний хэрэглээ, шим тэжээлийн нөхцөл байдлыг тодруулахад оршсон. Төсөл нь ядуурлын тойргоос гарч чадахгүй байсан, КОВИД-19 цар тахалын үед ажил орлогоо алдаж улам хүнд байдалд орсон өрхийн санхүүд дэмжлэг болж, бүх нас, хүйсийн хүний эрүүл мэнд, сэтгэл санаа болон гэр бүлийн гишүүдийн харилцаанд эерэг өөрчлөлт авчирч чадсан. Төслийн хүрээнд өрхийн хүнсний хэрэглээ, шим тэжээлийн нөхцөл байдлын талаарх судалгааг 3 удаагийн давтамжтай 96 өрхийн 612 хүнийг хамруулан хийсэн.



Зураг 1. Жил бүрийн 5 сард зохион байгуулдаг “Ногоон хороо” аяны үеэр иргэдэд мод тарих, орчноо тохижуулах ажлыг орон нутгийн эко бүлгийн хүүхдүүд манлайлан хийдэг.



Зураг 2. Иргэдийг үлгэрлэн манлайлах түшиц 5 өрхийн нэг болох Очирдарь хүнсний хаягдлаар бордоо хийж танилцуулсан нь хүмүүст үлгэр жишээ болсон. 2021 он



Зураг 3. Төслөөр хүүхдүүд хүнс тэжээлийн дутагдалд өртөхөөс сэргийлэх зорилгоор зорилтот өрхийн 612 гишүүнд халуун хоол, хүнс хүргэж өгсөн.

Шинэлэг түлхүүр хөгжил соёлын төв

Байгууллагын нэр	Шинэлэг түлхүүр хөгжил соёлын төв
Байгуулагдсан он	2021 он
Хаяг	Сонгинк хайрхан дүүрэг,Толгойт бүс
Утасны дугаар	88662444
E-mail	Shinelegchild@gmail.com
URL/Facebook	https://www.facebook.com/Shineleg-Child-Development-Centre-248383675324389/
Төлөөлөгчийн нэр	С.Бүрэнмэнд
Үйл ажиллагааны товч танилцуулга	<p>Манай байгууллага нь Толгойт бүсийн зорилтот бүлгийн эсрдэлт бүлэгт хамрагдах хүүхдүүдийг нийгэмшүүлэн хөгжүүлэх үйлчилгээг урлагаар дамжуулан үзүүлдэг.</p> <p>СХД-ийн Толгойт бүс нь хотын алслагдсан хэсэг бөгөөд энэ хэсэгт урьдчилан сэргийлэх болон хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээ ихээхэн шаардлагатай байдаг.</p> <p>Бид зорилтот бүлгийн хүүхдүүдээ сургуулийн орчинд гадуурхагдаж үлдээд байгаа жожиг гэгдэх хүүхдүүд болон өрх толгойлсон эцэг эх, хагас бүтэн өнчин хүүхдүүд тэдний харгалзан дэмжигч нарыг сонгон авч ажилладаг.</p> <p>Үйлчилгээг өдрийн цагаар болон хичээлийн бус цагаар үзүүлдэг бөгөөд японы тайшо кото (баруун зүүн тархи хөгжүүлдэг) хөгжмийн зэмсэгийг ашиглан хүүхэд бүрийн авьяас чадварт тохируулсан байдлаар гар урлал болон амьдрах ухааны сургалтуудаар дамжуулан хөгжүүлэх үйлчилгээг үзүүлэхээс гадна хүүхэд төвд байх хугацаандаа өөрийн гэртээ байгаа мэт орчинг бүрдүүлэхээс гадна халуун хоол болон бусад анхны тусламжийн үйлчилгээг шууд үзүүлэн ажилладаг юм.</p> <p>Ийнхүү хүүхдэд үзүүлэх үйлчилгээг цогцоор нь үзүүлсэнээр тэдэнд болон тэдний гэр бүлд гарах өөрчлөлт үр дүнг богино хугацаанд харах боломжтой юм.</p> <p>Бид зөвхөн хүүхэд гэхээсээ илүү тэдний гэр бүл харгалзан дэмжигч нартай хамтран тэдний үүрэг харицлага хандлагыг өөрчлөхөд анхааралаа хандуулан ажилладаг.</p>
Япон болон олон улсын хамтын ажиллагаа	Японы Нигата мужийн Кинген сургуулиас 2 жил тутуамд зохион байгуулагддаг Тайшо-Кото хөгжмийн олон улсын Фестивалд 2016 оноос хойш Монгол улсаа төлөөлөн жилд 3-4 хүний бүрэлдэхүүнтэй тус тэмцээнд амжилттай оролцдог.
ЖАЙКА-тай хамтарсан төсөл, хөтөлбөр	Одоогоор байхгүй



Ноосон эдлэлийн гар урлалыг дэмжих төв

Байгууллагын нэр	Ноосон эдлэлийн гар урлалыг дэмжих төв
Байгуулагдсан он	2007 он
Хаяг	Баянзүрх дүүрэг, 12-р хороолол, 116 тоот
Утасны дугаар	454676, 99315599, 88315599, 96885599
E-mail	Woolcraft_center@yahoo.com
URL/Facebook	
Төлөөлөгчийн нэр	Ц.Цэнд-Аюуш НЭГУД-ТББ гүйцэтгэх захирал
Үйл ажиллагааны товч танилцуулга	<ol style="list-style-type: none"> 1. Монгол дахь малын ноосыг ашиглан ноосны чиглэлээр эсгий урлалын анхан шатны болон гүнзгий шатны сургалтуудыг зохион байгуулдаг 2. Ноос түүхий эд бэлтгэн ноос будах түүхи эдээр хангах ажлыг зохион байгуулдаг 3. Ноосоор утас ээрэх, сүлжих сургалтыг зохион байгуулдаг 4. Хоршооллын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг хоршоодод звлөх үйлчилгээ үзүүлдэг <p>Анх Норвегийн сургалтын төв гэж байсан цагаас одоог хүртэлх хугацаандаа 22 аймагт эсгий урлалын сургалт зохион байгуулсан үүний үр дүнгээр 5000 гаруй хүнийг сургаад зогсохгүй бизнесийн гарааг эхлүүлэн олон өрхийн орлогыг нэмэгдүүлсэн.</p> <p>“Ноосон зангилаа”- дундын хоршооны “Цагаан-Алт” дэлгүүрийн үйлдвэрлэгчдийг сургасан том амжилт мөн гэж үздэг.</p> <p>Манай сургалтын байгуулага гэрээний 5-8 багштай, түрээсийн байранд үйл ажилагаа явуулдаг.</p> <p>Гүйцэтгэх захирал Ц.Цэнд- Аюуш миний бие тасралтгүй 26 жил ажилсаар ирсэн.</p>
Япон болон олон улсын хамтын ажиллагаа	<ol style="list-style-type: none"> 1. Норвегийн тусламжийн байгуулага төсөл 1995-2005 /10 жил/ 2. Японы Өвсний үндэс төсөл 2009-2011 /2 жил/ 3. Чехийн төсөл 2013-2014 /1 жил/ 4. Монгол-Солонгосын оюуни өмчийн төсөл 2015-2017 /2жил/
ЖАЙКА-тай хамтарсан төсөл, хөтөлбөр	Японы Өвсний үндэс төсөл 2009-2011 /2 жил/



Шинэ замнал

Байгууллагын нэр	Шинэ замнал
Байгуулагдсан он	2003 он
Хаяг	Сүхбаатар дүүрэг, 5-р хороо, 39 байр
Утасны дугаар	99099930
E-mail	mongolzuimelbrand@gmail.com
URL/Facebook	
Төлөөлөгчийн нэр	Ц.Сэлэнгэ
Үйл ажиллагааны товч танилцуулга	<p>Шинэ Замнал ТББ-н дэргэдэх Зүймэл даавуун урлалын төв нь 2004 онд байгуулагдсан.</p> <p>Зүймэл даавуун урлалаар дамжуулан өрх толгойлсон эмэгтэйчүүд, амьдралын баталгаажих түвшнээс доогуур орлоготой эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, тогтсон ажил мэргэжилгүй эмэгтэйчүүд, тэтгэвэрийн насны эмэгтэйчүүд, гэртээ хүүхдээ асарч байгаа эхчүүд эмэгтэйчүүдэд зориулан зүймэл даавуун урлалын сургалтыг явуулж, эргэх холбоотойгоор ажиллан, өрхийн орлогод нь тус нэмэр болох зорилготой ашгийн төлөө бус нийгэмл үйлчилдэг байгууллага юм.</p> <p>Зүймэл даавуун урлал гэж юу вэ?:</p> <p>Бид бүхний гар дор байдаг ч төдийлөн ашиглагддаггүй даавуу торгоны өөдсийг зүйн оёж, хөнжил, өлгий, орны бүтээлэг гэх мэт бүх төрлийн гэр ахуйн хэрэглэл, бэлэг дурсгалын зүйлс, урлагийн бүтээлийг урлаж болдог билээ. Зүймэл урлал нь Монголын зээгт наамалтай төстэй боловч даавуу, торгоны өөдсийг зүйж оёдоогоороо онцлог юм. Дэлхий дахинаа урлагийн түвшинд хүртлээ хөгжиж буй энэ урлалыг Монголдоо таниулан хөгжүүлж, иргэдийн чөлөөт цагаа зөв зохистой бүтээлч өнгөрүүлэхэд, юмханааар юм хийж сурахад нь чухал ач холбогдолтой.</p> <p>Дахин давтагдашгүй гайхамшигт цоо шинэ өнгө дизайны зохицол бүхий цор ганц гар урлалд дуртай хүмүүсийн тоо өсөн нэмэгдэж байгаатай холбоотой Зүймэл урлалын бүтээлүүдийг сонирхогчид, суралцагчид өдрөөс өдөрт нэмэгдсээр байгааг судалгаанаас харж болно.</p> <p>Ач холбогдол:</p> <p>Зүймэл урлал нь гарын доорхи материал буюу даавуу торгоны өөдөс ашигладаг учир эдийн засгийн үр ашигтайгаас гадна байгал орчинд ээлтэй байгал орчноо хамгаалах экологийн өндөр ач холбогдолтой урлал юм. Өөрөөр хэлбэл өмнө нь хүмүүс даавуу торгыг шатаах буюу дэр, матрасанд хийж ашигладаг байсан бол бид гэр ахуй бэлэг дурсгалын бүтээлүүд хийж дахин хэрэглээнд оруулдаг.</p> <p>Үйл ажиллагаа:</p> <p>Манай байгууллага Зүймэл урлалын сургалт явуулахаас гадна сургалтын төсөлд хамрагдсан төгсөгчдөөс сонгон 50 гаруй эрхэлсэн ажилгүй эмэгтэйчүүд, тэр дундаа өрх толгойлсон эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст гэрээр ажил олгон тэднийг дэмжин ажиллаж байна. Тэдний оёж урласан зүйлсийг нь гадаадын жуулчид, дотоодын худалдан авагчдад зориулан зарж борлуулан, амьдрал ахуйд нь чадах чинээгээрээ туслан ажилладаг.</p>
Япон болон олон улсын хамтын ажиллагаа	UNIFEM TAMA эмэгтэйчүүдийн групптэй хамтарж ажиллаж байсан.
ЖАЙКА-тай хамтарсан төсөл, хөтөлбөр	Байхгүй



Сэрсэн талын салхи

Байгууллагын нэр	Сэрсэн талын салхи
Байгуулагдсан он	2021 он
Хаяг	Архангай аймаг, Эрдэнэбулган сум, цогт уул 1-8тоот
Утасны дугаар	99102425, 88001782
E-mail	Amarsaikhan82@gmail.com
URL/Facebook	https://www.facebook.com/Nomadichomestays/
Төлөөлөгчийн нэр	Л.Амарсайхан
Үйл ажиллагааны товч танилцуулга	<p>Архангай аймгийн аялал жуучлал, хөдөө аж ахуй, боловсрол, худалдаа аж үйлдвэрллийг дэмжих.</p> <ul style="list-style-type: none"> ✓ Дотоод болон гадаадын жуулчдад Архангай аймгийн түүхэн дурсгалт газрууд, нүүдэлчидийн соёл ахуйг таниулан суртчилах. ✓ Хөдөө аж ахуйн хөгжлийг хурдасгах, малын гаралтай бүтээгдэхүүн, тэр дундаа сарлагийн сүү, хөөвөр зэрэгт өндөр ач холбогдол өгч, гадаад зах зээлд гаргах тал дээр гадаад тодоодын мэргэжлийн сайн дурынхныг ажиллуулах ✓ Газар тариалангийн салбарт шинэ салхи оруулах. Сонгино, сармисыг тарийлалтыг дэмжих, Хангайн зэрлэг улаан сонгиныг гаршуулах ✓ Архангай аймгийн хүүхэд залуудын гадаад хэлний боловсролыг дэмжих
Япон болон олон улсын хамтын ажиллагаа	Байхгүй
ЖАЙКА-тай хамтарсан төсөл, хөтөлбөр	Байхгүй

Монголын байгаль орчныг хамгаалах холбоо

Байгууллагын нэр	Монголын байгаль орчныг хамгаалах холбоо
Байгуулагдсан он	1975 он
Хаяг	Баянгол дүүрэг, 2-р хороо, 2-р хороолол, Энх тайвны өргөн чөлөөний гудамж, 40/2
Утасны дугаар	Ажил: 21-252728, гар утас: 99142102
E-mail	masne_mon@yahoo.com
URL/Facebook	
Төлөөлөгчийн нэр	МБОХХолбооны ерөнхийлөгч Нанзад овогтой Бадамханд
Үйл ажиллагааны товч танилцуулга	<p>Зорилго,чиглэл: Байгаль орчныг хайрлан хамгаалах, нөөц баялгийг зөв зохистой ашиглах, нөхөн сэргээх, экологийн тэнцвэртэй хөгжлийг хангах, хүн амын эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, сургалт, сурталчилгаа явуулах, байгаль хамгаалах үйл хэрэгт иргэд, олон нийтийн хүч оролцоог өргөтгөн зохион байгуулж ажиллах, төрийн байгууллагын зарим чиг үүргийг гэрээ захиалгын үндсэн дээр гүйцэтгэх, байгаль орчинд сөрөг нөлөөгүйгээр экологийн аялал жуулчлал эрхлэх, дүрс бичлэгийн кино хийх, сонин сэтгүүл, хэвлүүлэх зэрэг үйл ажиллагааг эрхлэх. -Байгаль орчныг хамгаалах зорилт бүхий төрийн болон төрийн бус байгууллагатай болон олон улсын байгаль орчныг хамгаалах холбоо төвүүд, ивээн тэтгэгч байгууллагуудтай харилцаа тогтоож хамтран ажиллах, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх.</p> <p>Хүрээ: Үндэсний хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг, 21 аймагт байгаль хамгаалах салбар зөвлөлтэй, гишүүн байгууллагуудтай, гишүүнчлэлтэй, нийгэмд үйлчилдэг.</p>
Япон болон олон улсын хамтын ажиллагаа	<p>1991 онд Япон Улсын Осака хот дахь Япон-Монголын соёл, эдийн засгийн хамтын ажиллагааны нийгэмлэгтэй экологийн жуулчид хүлээн авах гэрээ байгуулж 1992 оноос жуулчдыг хүлээн авч Монголоор аялуулж байсан. *Монгол орны Хустайн нуруунд нутагшиж буй “Тахь нутагшуулах” талаар АНУ, Канад, Англи, Япон, Голланд, Австрали, Швед, Норвег, Чех улсын баримтат кино, телевизийн нэвтрүүлгийн зураг авалтуудыг зохион байгуулсан. *1993 онд Япон улсаас Монгол улсад суугаа Элчин сайдын яамнаас МБОХХ-ны үйл ажиллагааг дэмжсэн 14,0 мянган ам долларын дэмжлэг тусламжийг Холбооны ажлын алба, 18 аймгийн салбар зөвлөлүүд видео, техник хэрэгслээр хангагдсанаар мэдээлэл, сургалт сурталчилгааны ажилд ихээхэн үр дүн өгсөн. *1995 оны 8-сард “Зүүн Азийн агаар мандлын үйл ажиллагааны сүлжээ” (AANEА) Олон улсын төрийн бус байгууллагад мөн 1997онд Дэлхийн байгаль, байгалийн нөөцийг хамгаалах холбоо (IUCN)-нд гишүүнээр элсэн орсон. 2012 оноос Япон улсын Байгаль орчныг хамгаалах Технологи Шилжүүлэх Олон Улсын (ICETT) төв байгууллагатай харилцаа холбоо тогтоож, улмаар 2014 оны 12 сард Япон-Азийн залуу үеийнхний шинжлэх ухааны салбар дахь солилцооны хөтөлбөрийг хүрээнд УБ хотын 9 дүүргийн Ерөнхий Боловсролын Сургуулийн Эко бүлгийн 10 сурагчдыг Япон улс руу аялуулж, Токио хотын хөгжил, аж үйлдвэрлэлийн технологийн дэвшил болон байгаль орчны бохирдол нийгмийн гамшгийг даван туулсан Ёккаичи хот туршлагыг судлан танилцах сургалтын аяллыг зохион байгуулж хамтран ажилласан.</p> <p>МБОХХ нь Гадаад улс орнуудын Байгаль орчныг хамгаалах нийгэмлэгүүд, Элчин сайдын яамнуудтай хамтран ажиллаж, орон нутгийн БО-ны ТББ-ын чадавхыг дээшлүүлэх, бүх нийтийн экологийн боловсролыг сайжруулах чиглэлээр ажиллаж ирсэн.</p>
ЖАЙКА-тай хамтарсан төсөл, хөтөлбөр	Байхгүй

Монголын байгаль орчны иргэний зөвлөл

Байгууллагын нэр	Монголын байгаль орчны иргэний зөвлөл (МБОИЗ)
Байгуулагдсан он	2008 он
Хаяг	Хан-Уул дүүрэг,11-р хороо, Зайсан цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төв 310 тоот
Утасны дугаар	70131400
E-mail	lrgenii.zuwlul@gmail.com
URL/Facebook	Монголын Байгаль Орчны Иргэний Зөвлөл
Төлөөлөгчийн нэр	С.Амгаланбаатар
Үйл ажиллагааны товч танилцуулга	<p>МБОИЗ-өөс Байгальд ээлтэй эрдэс баялгийн бодлогын эрх зүйн орчинг бий болгох, улс төржилтөөс ангид байлгах, шийдвэр гаргах түвшинд байгаль орчны иргэний нийгмийн байгууллагуудын оролцоог хангах, ил тод хариуцлагатай уул уурхайн хяналтыг бий болгох зорилгоор хамтарсан тунхаг бичигт нэгдсэн. Байгаль орчны тэнцэл, унаган төрх, түүх, соёлын өвийг хадгалан хамгаалахад болон байгалийн аялал жуулчлалыг хөгжүүлэхэд ач холбогдол бүхий газар нутгийг хамгаалалтанд авахыг дэмжиж ажилласны үр дүнд УИХ-ын тогтоол гарах бэлтгэл ажлыг хийлцэж батлуулсан. МБОИЗ-ийн дэргэдэх Ногоон парламентаараа дамжуулан байгаль орчны чиглэлийн төдийгүй олон чиглэлийн хууль тогтоомжийн төсөл, хэрэгжилт, давхардал хийдэл зэргийн талаар судалдаа хэлэлцүүлэг явуулж гарсан шийдвэрийг холбогдох яам тамгийн газар, төрийн байгууллагуудад шат дарааллын хүрээнд танилцуулан ажиллаж ирсэн. 2016-оны 3 сард эхлэн БОАЖЯ-ны санхүүжилтээр 21 приус, 64 ТББ Агаарын бохирдлын эх үүсвэрүүд ба АБ бууруулах арга замын талаархи судалгаа хийсэн(13,2 сая төгрөг), 2017-2019 онд жил бүр БОАЖЯ-аас 20-30 сая төгрөгийн санхүүжилт авч “Агаарын бохирдлыг бууруулахад иргэдийн оролцоог дээшлүүлэх”, “Агаарын бохирдлыг бууруулахад зайлшгүй хэрэглэх дэвшилтэт техник технологийн нээлттэй үзэсгэлэн”-г 11 сарын 20-оос дараа жилийн 3 сарын 1 хүртэл Нийслэлийн Чингэлтэй, Сүхбаатар, Сонгинохайрхан, Хан-Уул, Баянзүрх дүүргүүдэд ажиллуулахын зэрэгцээ, уул уурхайн нөлөөллийг бууруулах, модны хулгай, газрын бүрхүүлийн өөрчлөлтийн чиглэлүүдээр хяналт мониторингийн ажлуудыг ойн сан бүхий аймгуудаар тогтмол хийж ирсэн. БОАЖЯ-ны шууд санхүүжилтээр “Булаг шанд гол мөрний эх хамгаалах сан”, “Шүхэрчдийн холбоо”, “Ногоон соёл иргэншил хөгжил сан ТББ”, “Ногоон гарц” зэрэг ТББ-ууд УБ хотын агаарын бохирдлыг бууруулах жижиг төслийг удирдаж 15 ТББ-ын оролцоог хангаж ажиллав. 2019 оны 9 сард Азийн зэрлэг амьтдын Долоо хоногийг БОАЖЯ-тай хамтран анх удаа Монголд зохион байгуулж, том хөхтөн амьтдыг хамгаалах талаар ОУ-ын хурал зохион байгуулсан. ЭкЦА, МХЕГ, ГХЯ-тай хамтран МБОИЗ-ийн мэргэшсэн гишүүн байгууллагуудын оролцоог хангаж ажиллах хамтын ажиллагааны суурийг тавьсан. Санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг нээлттэй, ил тод болгосон. 2017,2018 оны санхүүгийн тайланд аудит хийлгэн дотоодын болон олон улсын байгууллагуудад ил тод тайлагнав. Яам, түүний харьяа байгууллагаас зарласан аливаа тендерийн хороонд байгаль орчны чиглэлийн ТББ-дын төлөөллийг оролцуулдаг болсон. 2018.03.22-ны Дэлхийн усны өдрийг угтан хүүхэд, залуучуудын "Ус-Хөгжил" БОАЖЯ, ШУТИС, Усны судалгааны төв хамтран анхдугаар чуулганыг ШУТИС-ийн Урлаг танхимд зохион байгууллаа. Чуулганы үеэр усны нөөц ба менежмент, усны үнэ цэнэ үнэлэмж сэдвээр хэлэлцэж зөвлөмжүүдийг бэлтгэсэн. Жил бүр усны өдрийг өргөн хүрээнд тогтмол тэмдэглэдэг болсон.</p>
Япон болон олон улсын хамтын ажиллагаа	<p>2015 онд Харвардын их сургуулийн тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд байгаль орчны мониторинг хийхэд QGIS-ийг ашиглах, зураглах арга зүйн сургалтанд 12 ТББ хамрагдсан. GCS ОУ-ын байгууллагын дэмжлэгээр Англи, Сингапураас зөвлөх багш нар МБОИЗ-ийн ажлын албан дээр зочилж 24 ТББ-д Design thinking, cost benefit analysis болон төслийн удирдлага, ногоон барилга байгууламж, ногоон хот төлөвлөлт, хог хаягдлын менежмент-компостын технологийн сургалт зохион байгуулж, сургагч багш нарыг бэлтгэж өгсөн. 2015 оны 3 сарын 25-аас 2016 оны 4 сар хүртэл АНУ-ын Азийн сангийн дэмжлэгээр бичил уурхайн ашиглалтаас хаягдсан газруудад техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх, сумын байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах арга зүйн сургалтуудад МБОИЗ-ийн гишүүн байгууллагуудыг хамруулж, үндэсний сургагч багшаар бэлтгэж, төслийн санхүүжилтийг төсөлд</p>

	<p>хамрагдсан ТББ-ууд, МБОИЗ-ийн орон нутаг дэх салбар зөвлөлүүдэд шууд өгч амжилттай хэрэгжүүлсэн. 2014 оны 8 сард NASA, МУИС, МБОИЗ-ийн санхүүжилтээр “Тандан судалгаа-инноваци Монголд” сэдэвт олон улсын ЭШ-ний хурал, 2015 оны 5 сарын 27-28-ны өдрүүдэд Азийн сан, уул уурхайн ассоциаци, ЕСБХБанкны санхүүжилтээр “Биологийн олон янз байдал, төрөл зүйлийг дүйцүүлэн хамгаалах олон улсын стандарт зарчимууд, туршлага-сургамж” сэдэвт Олон улсын эрдэм шинжилгээний бага хурлыг байгаль орчны чиглэлийн ТББ-ууд, үнэлгээний компаниуд, БОАЖЯ, Олон улсын судлаач, эрдэмтэд, Монгол дэх донор байгууллагуудын мэргэжилтнүүд, бүсийн зөвлөхүүдийн оролцоотой зохион байгуулав. АНУ-ын Нью Мексикийн Зүүн өмнөд Эргийн байгаль орчны судалгааны төвтэй хамтран 2014-2016 онуудын 8 сард ОХУ, АНУ, Монголын ТББ-ууд, эрдэмтэн судлаачидын хамтарсан хээрийн судалгаа-туршлага солилцооны хөтөлбөр хэрэгжүүлж жил бүр 2 хүн АНУ, 10 хүн Монголд зуны судалгааны ажилд хамрагдаж, чадавхижиж байна. Байгаль орчны чиглэлийн олон улсын болон үндэсний хэмжээний хурал, зөвлөгөөнд оролцуулах, сургалтанд хамруулах хүрээнд 2018 оны 5 сарын 9-5 сарын 28-ны өдрүүдэд "Монголын тал хээрийн цөлжилт, элсэн шуурганаас сэргийлэн хамгаалах, хариу арга хэмжээ авах мэргэжлийн семинар"-г МБОИЗ болон НҮБ-ын Даян Дэлхийн Байгаль орчны жижиг төслийн газраас санхүүжилттэй "ХӨДӨӨ ГЭР" төслийн 5 аймгийн 35 малчин нөхөрлөлийн төлөөлөл оролцож байна. Тус сургалтад БОАЖЯам болон аймгуудын холбогдох мэргэжилтэнүүд, байгал орчны ТББ-ийн төлөөлөл 29 хүн оролцож байна.</p>
<p>ЖАЙКА-тай хамтарсан төсөл, хөтөлбөр</p>	<p>Байхгүй</p>



Ус, ариун цэвэр, эрүүл ахуйн дэвшлийн төв

Байгууллагын нэр	WASH Action of Mongolia (Ус, ариун цэвэр, эрүүл ахуйн дэвшлийн төв)
Байгуулагдсан он	2014 он
Хаяг	Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Гэрэл төв, 302 тоот
Утасны дугаар	330368
E-mail	ariunaa@washaction.mn, bodigerel@washaction.mn
URL/Facebook	https://www.facebook.com/WaSHAction
Төлөөлөгчийн нэр	П.Ариунаа
Үйл ажиллагааны товч танилцуулга	<p>Бид 2014 оноос:</p> <ul style="list-style-type: none"> - Усны хүртээмжийг нэмэгдүүлэх, усны зохистой хэрэглээг сурталчлах - Бие даасан ариун цэврийн байгууламжийн хувилбаруудыг бий болгох, хүрээлэн буй орчны ариун цэврийг сайжруулах: ахуйн хог хаягдал, органик хор хаягдлыг дахин ашиглах - Сургууль, цэцэрлэг, дотуур байрын ариун цэврийн байгууламж, эрүүл ахуйн нөхцлийг сайжруулах - Олон нийтэд эрүүл ахуйн зөв дадлыг хэвшүүлэх, зан төлвийг сурталчлах чиглэлээр төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлсээр ирсэн. <p>Ялангуяа БШУЯ болон НҮБ-ын Хүүхдийн Сантай хамтран цэцэрлэг, сургууль дотуур байрын ус хангамж ариун цэврийн байгууламжийн нөхцлийг сайжруулж эрүүл ахуйн зөв дадал хэвшлийг сурталчлах чиглэлээр тасралтгүй ажиллаж байна.</p> <p>Энэ хүрээнд УБ хотын алслагдсан дүүрэг, орон нутгийн сургуулийн ариун цэврийн байгууламжийг шинэчлэн сайжруулах олон ажлууд хийснээс гадна олон нийтэд мэдээлэл өгөх, сурталчлах компани аянуудыг зохион байгуулж олон нийтийн хандлагыг өөрчлөхөд хувь нэмрээ оруулсаар байна.</p> <p>Эрүүл мэндийн багш нарын ур чадварыг сайжуулахад дэмжлэг үзүүлэх, www.wash.edu.mn болон өсвөр насны охидод сарын тэмдгийн эрүүл ахуйн боловсрол олгох www.namuu.mn болон ОКУ аппликейшнийг ажиллуулж байна.</p>
Япон болон олон улсын хамтын ажиллагаа	<p>Бид НҮБ, Азийн Хөгжлийн Банк, Форд Сан, Канад Сан, Азийн Сан, ACF International, Rustic Pathway зэрэг байгууллагуудтай хамтран төсөл хөтөлбөрүүд хэрэгжүүлсээр ирсэн.</p> <p>Мэргэжлийн чиглэлийн SUSANA, Water keeper Alliance, Water Institute, Global water partnership байгууллагуудын гишүүнчлэлтэй бөгөөд сургалт, туршлага солилцох, мэргэжил дээшлүүлэх зэргээр хамтран ажилладаг.</p>
ЖАЙКА-тай хамтарсан төсөл, хөтөлбөр	Байхгүй



Зураг 1: Өрхийн ариун цэврийн байгууламжийг 2 тасалгаат, хүүхдэд ээлтэй байдлаар шийдсэн нь. 2020 онд Баянхонгор аймгийн төвд



Зураг 2: БЗД-н 85-р сургуулийн барилгад залгаж барьсан ариун цэврийн байгууламж, 2017 он



Байгаль орчин эрүүл мэнд төв

Байгууллагын нэр	Байгаль орчин эрүүл мэнд төв
Байгуулагдсан он	2007 он
Хаяг	Чингэлтэй дүүрэг, 4-р хороо, Бага тойруу 47-03
Утасны дугаар	99132958, 95257562
E-mail	dula_lod@yahoo.com
URL/Facebook	
Төлөөлөгчийн нэр	Л.Дугармаа
Үйл ажиллагааны товч танилцуулга	<p>“Байгаль орчин, эрүүл мэнд төв” ТББ нь байгаль орчныг хамгаалах, түүнийг бохирдол, доройтлоос сэргийлэх, байгаль орчин, орчны - эрүүл ахуй, эрүүл мэндийн талаар зөвлөлгөө өгөх, сургалт зохион байгуулах, судалгаа хийх зорилготойгоор 2008 онд байгуулагдсан.</p> <p>Байгууллагын удирдах зөвлөлд экологч, орчны эрүүл ахуйч, их эмч, химич, токсикологч эмч, хуулч зэрэг мэргэжлийн хүмүүсээс бүрддэгээс гадна төрийн байгууллагад 26 жил, ТББ байгууллагад 5-аас дээш жил ажилласан, профессор, доктор, магистер цолтой, тодорхой мэргэжил боловсролтой, туршлагатай хүмүүс ажилладаг.</p> <p><u>Тус байгууллагаас хийсэн зарим ажлуудаас дурьдахад:</u></p> <ol style="list-style-type: none"> 1. Тус төвийн тэргүүн болон бусад хүмүүс нь Нидерландын Вант Улсын Засгийн газар болон НҮБ-ын Хөгжлийн Программын санхүүжилтээр (“Байгаль орчны засаглалыг бэхжүүлэх МОН/07/104”), “Байгаль орчин, аялал жуулчлалын яам (БОАЖЯ)-ны загвар нэгдсэн төлөвлөгөөг боловсруулах” төслийн ажлын хэсгийн ахлагчаар ажиллан төслийн амжилттай хэрэгжүүлсэн. 2. Олон улсын хэмжээнд баримтлаж байгаа “Эх үүсвэрээс гарах хог хаягдлын кодчилсон жагсаалт, тэдгээрийн аюулын зэрэглэл” -ийг Европын Холбооны Улсын жишгээр боловсруулж БОАЖЯ хүргүүлсэн. 3. Нээлттэй нийгэм форумас зарласан тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд “Аюултай хог хаягдлын менежментийг сайжруулах, олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх компани т ажил” төслийн хүрээнд Аюултай хог хаягдлын талаар 3 ном бичиж хэвлүүлсэн. Үүнд: <ul style="list-style-type: none"> ○ Аюултай хаягдал ○ Цахим ба цахилгаан хэрэгслэлийн хаягдал ○ Асбестын хаягдал <p>Эдгээр ном товхимлыг бүх аймаг хотын байгаль орчны газрууд болон мэргэжилтнүүдэд ном хэлбэрээр болон цахим хэлбэрээр тараасан болно</p> <ol style="list-style-type: none"> 4. АНУ-ын Дэлхийн Нөөцийн Хүрээлэнгийн санхүүжил болон Нээлттэй нийгэм форумтай хамтарч “Байгаль орчны бохирдлын нэгдсэн мэдээлэл” төслийг хэрэгжүүлсэн. Энэ төслийн хүрээнд <ul style="list-style-type: none"> • “Сумын хог хаягдлын менежментийн гарын авлага” брошур • “Голын усны бохирдлын байдалд олон нийтийн хяналт хийх гарын авлага” брошур • Усны засаглал. Энэ сэдвийн хүрээнд хэд хэдэн хэлэлцүүлгийг усны мэргэжлийн хүмүүс төрийн их дээд сургуулийн багш нар, мэргэжлийн институт судлаачдын дунд зохион байгуулсан мөн энэ сэдвээр Л.Долгормаа “ХӨГЖЛИЙН ТҮЛХҮҮР УС” ном 2018-д “Усны Засаглал” өгүүлэг гаргасан. • Туул голын сав газарт мониторинг хийх зэрэг ажлуудыг хийсэн. 5. Нээлттэй нийгэм форум, Байгаль орчны шинэчлэл-2 төслөөр “Орон нутгийн байгаль орчны асуудал эрхэлсэн мэргэжилтнүүдийг чадавхижуулах” сургалтыг Дархан хотод зохион байгуулсан. Энд сургалтад Дархан-Уул, Орхон, Сэлэнгэ аймгийн бүх сумдын байгаль орчны мэргэжилтэн, байцаагч нарыг

	<p>хамруулсан.</p> <p>6. “Хариуцлагатай уул уурхайн санаачилга” ТББ-тай хамтран Монгол Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа уул уурхайн үйл ажиллагааг хариуцлагатай болгох, ялангуяа орчныг бохирдол доройтлоос хамгаалах зорилгоор “Хариуцлагатай уул уурхайн шалгуур үзүүлэлт” боловсруулах ажлын хэсгийн ахлагчаар ажиллан, шалгуур үзүүлэлтийг боловсруулан, энэ үзүүлэлтүүдээр Монгол Улсад Хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх чиглэл баримтлахаар 2012 оноос эхлэн Засгийн газрын хөтөлбөрт оруулсан .</p> <p>7. Тус төв нь хөдөө аж ахуйд хэрэглэж буй химийн хорт бодисын хяналт, судалгааны чиглэлээр ажиллахаар зорьж байгаа юм. Өнөөгийн байдлаар бид газар тариаланд хэрэглэж байгаа химийн хорт бодис пестицидийн тухай “Пестицидийн тухай 44 асуулт” товхимлыг орчуулсан “Хүнс-Эвсэл” ТББ-тай хамтран хэд хэдэн сургалт семинарыг хийсэн.</p> <p>8. Нээлттэй нийгэм форумын санхүүжилтээр “Эмнэлэг, шүдний эмнэлэг, эмийн санд мөнгөн ус агуулсан багаж, хэрэгслэл хэрэглэж, борлуулж байгаа эсэхэд Мониторинг судалгаа” хийх төслийг Улаанбаатар хот, Дархан Сэлэнгэ аймгийн хэмжээнд хяналт хийж тайлан гаргасан.</p> <p>9. “Пестицидийн хэрэглээний зохистой байдлын мониторинг” Төв, Сэлэнгэ аймгийн зарим сумдад тариалж байгаа ногоо, болон Хүнсний том супермаркет захуудад худалдаалж байгаа хүнсний ногоо, жимснээс 73 дээж авч пестицид тодорхойлуулан дүгнэлт, тайлан гаргаж зохих газруудад явуулсан. Энэ хүрээнд бид олон улсын хэмжээнд ашиглаж болох болон ашиглахыг хориглосон пестицидийн жагсаалттай харьцуулан судлаж үзлээ. Европын Холбооны Улсын пестицидийн мэдээллийн сан (EU Pesticides Database-European Commission)-д олон улсын хэмжээнд ашиглаж байгаа болон ашиглахыг хориглосон 1418 пестицидын жагсаалтаас хориглосон пестицидийг манай улсад ашиглаж болох пестицидийн жагсаалттай харьцуулан судаллаа.</p>
Япон болон олон улсын хамтын ажиллагаа	АНУ-ын Дэлхийн нөөцийн хүрээлэнтэй хамтарч төсөл хэрэгжүүлсэн.
ЖАЙКА-тай хамтарсан төсөл, хөтөлбөр	Байхгүй

“Байгаль орчны бохирдлын нэгдсэн мэдээлэл” төслөөр хийсэн хэлэлцүүлэг



Ирээдүйн хөгжлийн хүрээлэн

Байгууллагын нэр	Ирээдүйн хөгжлийн хүрээлэн(IFF-Institute for Future)
Байгуулагдсан он	2005 он
Хаяг	Хан-Уул дүүрэг, Цэнгэг усны төв 303 тоот
Утасны дугаар	99129913, 99251884
E-mail	ochbol35@gmail.com, misheelmaral0505@gmail.com, tunza_mgl@yahoo.com
URL/Facebook	www.facebook.com/Ирээдүйн-Хөгжлийн-Хүрээлэн
Төлөөлөгчийн нэр	М.Оюунчимэг, Б.Мишээл
Үйл ажиллагааны товч танилцуулга	Манай байгууллага нь дараах дөрвөн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг. 1. Тогтвортой хөгжил, байгаль орчин, нийгмийн болон орчны эрүүл мэндийн чиглэлээр судалгаа хийдэг. 2. Тогтвортой хөгжлийн боловсрол, байгаль орчныг хамгаалах чиглэлээр мэдлэг олгох, чадавхи бэхжүүлэх сургалтын модуль хөтөлбөр боловсруулж, сургалт зохион байгуулдаг. 3. Тогтвортой хөгжлийн боловсрол, зан үйлийг өөрчлөх мэдээлэл харилцааны үйл ажиллагаануудыг зохион байгуулдаг. (ухуулга, нөлөөлөл, хэвлэл мэдээлэл олон нийтийн кампанит ажлууд) 4. НҮББОХ-ын ТУНЗА сүлжээний хүрээнд олон улсын залуучуудын, сайн дурын болон байгаль орчны байгууллагуудтай нягт хамтран ажилладаг.
Япон болон олон улсын хамтын ажиллагаа	Ирээдүйн хөгжлийн хүрээлэн нь НҮБ-ийн байгаль орчны хөтөлбөрийн (НҮББОХ) ТУНЗА олон улсын болон бүсийн хэмжээний хурал, чуулган, уулзалтуудад хүүхэд, залуучуудын төлөөллийг идэвхитэй оролцуулсаар ирсэн. Түүнчлэн НҮББОХ-ын ТУНЗА зүүн хойд Азийн залуучуудын байгаль орчны сүлжээний (NEAYEN) олон улсын хурлыг эх орондоо 2008 болон 2013 онуудад зохион байгуулсан ба БНХАУ, БНСУ, Япон улсуудад НҮББОХ ТУНЗА олон улсын залуучуудын болон хүүхдийн хурлуудад мөн 2008-2010 онуудад Монгол улсаа төлөөлөн оролцох сайн дурын гишүүдийг сонгон, оролцуулав. 2021 онд Моск COP 26 олон улсын залуучуудын хуралд гүйцэтгэх захирал Б.Мишээл нь Монгол улсаа төлөөлөн дээд-төвшний тунхаглалыг илтгэв.
ЖАЙКА-тай хамтарсан төсөл, хөтөлбөр	Ирээдүйн хөгжлийн хүрээлэн нь ЖАЙКА-тай хамтран ажиллаж байсан удаагүй бөгөөд цаашид байгаль орчин, сайн дурын үйл ажиллагаа, хүүхэд, залуучуудын хөгжил, манлайлал болон оролцоо чиглэлээр хамтран ажиллах хүсэлтэй байна.



Байгаль орчны мэдээлэл сургалтын төв

Байгууллагын нэр	Байгаль орчны мэдээлэл сургалтын төв
Байгуулагдсан он	2003 он
Хаяг	Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Энхтайваны өргөн чөлөө, Шүрэн оффис 5 тоот
Утасны дугаар	88111893
E-mail	Ceo@feemongolia.mn
URL/Facebook	https://www.facebook.com/FEE.Mongolia https://www.facebook.com/EcoSchoolMongolia
Төлөөлөгчийн нэр	Тэргүүн Л.Тэмүүжин
Үйл ажиллагааны товч танилцуулга	<p>Дэлхийн байгаль орчны боловсролын сан (FEE) ийн гишүүн, Байгаль орчны мэдээлэл сургалтын төв (БОМСТ) НҮТТБ нь 2003 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд 19 дэх жилдээ тасралтгүй үйл ажиллагаа явуулж байна. Дэлхийн байгаль орчны боловсролын сан (FEE)-ийн гишүүн байгууллагын хувьд Олон улсын эко-сургууль, Ойн тухай суралцахуй, Байгаль орчны залуу сурвалжлагч, Цэнхэр туг, Ногоон түлхүүр гэсэн хөтөлбөрүүдийг Монгол Улсад хэрэгжүүлэгч албан ёсны үндэсний оператор байгууллага юм. Монгол улсад Швейцарийн хөгжлийн агентлагийн дэмжлэгтэйгээр “Байгаль орчны мэдээлэл сургалтын төв” нь 2007 оноос “Эко сургууль” хөтөлбөрийг туршиж, 2011 оноос ДБОБС-ийн албан ёсны эрхтэйгээр хэрэгжүүлж байна. 2015 оноос эхлэн Швейцарын хөгжлийн агентлагийн санхүүжилтээр “Байгаль орчин, аялал жуулчлалын яам”, “Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам”-тай хамтран хэрэгжүүлж буй “Тогтвортой хөгжлийн боловсрол” төсөлтэй хамтран үйл ажиллагааны цар хүрээг өргөжүүлж ирсэн. 2020 оны байдлаар ОУ-ын эко-сургууль, Ойн тухай суралцахуй, Байгаль орчны залуу сурвалжлагч хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх хүрээнд 21 аймаг, нийслэлийн ЗДТГ болон БОАЖГ, БСУГ-тай хамтран ажиллаж байгаа бөгөөд зөвхөн эко-сургууль хөтөлбөрт нийслэл, орон нутгийн нийт 341 ерөнхий боловсролын сургууль, 204 цэцэрлэг, 6 политехникийн коллежийг хамруулаад байна.</p>
Япон болон олон улсын хамтын ажиллагаа	Олон улсын Эко-сургууль хөтөлбөр нь дэлхийн 70 гаруй улс оронд хэрэгжиж буй хөтөлбөр
ЖАЙКА-тай хамтарсан төсөл, хөтөлбөр	Байхгүй





Хомын талын тахь

Байгууллагын нэр	Хомын Талын Тахь ТББ
Байгуулагдсан он	2014 он
Хаяг	Баянзүрх дүүрэг , 1-р хороо, Сөүл Бизнес Центр 703 тоот
Утасны дугаар	70004480
E-mail	takhi@ktt.mn
URL/Facebook	www.takhi.mn, FB: Khomyn talyn takhi
Төлөөлөгчийн нэр	Ц.Мөнхбат /Гүйцэтгэх захирал/
Үйл ажиллагааны товч танилцуулга	<p>Завхан аймгийн Дөрвөлжин сумын нутагт орших Хомын талыг суурь судалгаа явуулсны үндсэн дээр тахь сэргээн нутагшуулах Монгол орны гурав дахь газраар сонгож, тахь сэргээн нутагшуулах бэлтгэл ажлыг 2000 оноос эхлүүлж, Франц улсаас 2004 онд 12, 2005 онд 10, Чех улсаас 2011 онд 4 тахь, нийт 26 тахь тээвэрлэн авчирсан нь 2021 оны байдлаар 8 үржлийн сүрэгт хамаарах 120 гаруй тахь болон өсөж, амжилттай нутагшсан.</p> <p>Хомын тал нь УИХ-ын 2020 оны 5-р сарын 7-ны өдрийн 46-р тогтоолоор ТХГН-ийн сүлжээнд хамрагдан Дөрвөлжин сумын Онц, Тавантолгой, Буурал багуудын нутаг дэвсгэрийг хамарсан 411,403.80 га талбай нутгийг байгалийн цогцолбор ангиллаар улсын тусгай хамгаалалтад авсан.</p> <p>2004 оноос тахь сэргээн нутагшуулах, байгаль хамгаалах ажлыг анх “Тахь” төсөл нэртэйгээр явуулж байсан бөгөөд улмаар 2014 онд “Хомын талын тахь” ТББ байгуулагдсан ба Францын Тахь Хамгаалах Холбооноос 2016 онд тус үйл ажиллагааг шилжүүлэн авсан байдаг.</p> <p>Тус байгууллага нь нийт 14 ажилтантай. Үүнээс 10 ажилтан нь Хомын талд тахийн судалгаа, мониторинг болон амьдрах орчныг хамгаалах чиглэлээр, 4 ажилтан нь Улаанбаатар хотод байгууллагын хөгжил, хамтын ажиллагаа, захиргаа, санхүүжилт, хүний нөөц, судалгаа шинжилгээний ажлыг удирдан чиглүүлэх үүрэгтэйгээр ажилладаг.</p> <p>Нийт ажилтнуудын 50-аас дээш хувь нь байгаль хамгаалал, экологи, биологийн мэргэжлээр бакалавраас дээш зэрэгтэй. Хомын талд тахь сэргээн нутагшуулж буй тахийн зан төрх, эрүүл мэндийн ажиглалт судалгааг өдөр бүр хийж, амьдрах орчныг хамгаалж буйн зэрэгцээ цаашид тахийг байгальд суллан тавих, улмаар байгаль дээр бие даан амьдрах чадвар бүхий популяци бий болгох зорилго тавин ажиллахын зэрэгцээ Цагаан зээр, онгол бөхөн, Хар сүүлт зээр, Янгир зэрэг нэн ховор, ховор амьтдын болон Хомын талын бэлчээр, ургамлын мониторинг судалгааг тасралтгүй хийж, зэрлэг амьтдын тоо толгойг нь тогтвортой өсгөх, амьдрах орчныг нь хамгаалах зорилгоор тогтвортой үйл ажиллагаа явуулж байна.</p>
Япон болон олон улсын хамтын ажиллагаа	Тахь хамгаалах чиглэлээр Францын Тахь Хамгаалах Холбоо, TNC, WWF, IUCN, аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр Германы “Natucate” компани, “Nomadic Journey” ХХК-тай, улсын тусгай хамгаалалттай газрын менежментийн чадавхыг бэхжүүлэх чиглэлээр Швейцарын “MAVA”, “Rolex” сангууд, Германы олон улсын Хамтын Ажиллагааны Байгууллага (GIZ)-ын “SPACES”, ХБНГУ-Монгол улсын Засгийн газрууд, Хөгжлийн Банк (KfW)-ны хамтарсан “Биологийн олон янз байдал, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох” зэрэг төслүүдтэй тус тус хамтран ажилладаг.
ЖАЙКА-тай хамтарсан төсөл, хөтөлбөр	Байхгүй



Хар тамхи, мансууруулах бодисоос иргэдийг хамгаалах нийгэмлэг

Байгууллагын нэр	Хар тамхи, мансууруулах бодисоос иргэдийг хамгаалах нийгэмлэг ТББ
Байгуулагдсан он	1999 он
Хаяг	Чиэгэлтэй дүүрэг, 2-р хороо, Их тойруу 15-1, Ренталон байр 219 тоот
Утасны дугаар	99199228
E-mail	appdomongolia@gmail.com, shikhagvasuren2014@yahoo.com
URL/Facebook	https://www.facebook.com/appdomongolia
Төлөөлөгчийн нэр	Гүйцэтгэх захирал Ш.Лхагвасүрэн
Үйл ажиллагааны товч танилцуулга	<p>ХТМБИХН-ийн хэтийн зорилго</p> <p>Архи, тамхи, мансууруулах бодисгүй эрүүл орчин бүрдүүлэх, ХДХВ/ДОХ/БЗДХ-оос урьдчилан сэргийлэх, мансууралгүй улс орон, ард иргэдтэй болох, эрүүл аж төрөх зан үйлийг төлөвшүүлэх, хүмүүнлэг ардчилсан нийгмийн хөгжилд хувь нэмэр оруулах зорилготой.</p> <p>ХТМБИХН-ийн зорилт</p> <p>1. Нийт иргэдийн дунд архи, тамхи, хар тамхи мансууруулах бодисын хэрэглээний байдлыг тодорхойлох үнэлгээ судалгаа хийж, архи, тамхи, мансууруулах бодисын хор хөнөөл, дам тамхиталтаас сэргийлэх, эрүүл орчин бүрдүүлэхийн ач холбогдлын талаар сургалт сурталчилгаа зохион байгуулан хийж гүйцэтгэх.</p> <p>2. Хүүхэд, залуучуудыг хар тамхи мансууруулах бодис хэрэглэхээс урьдчилан сэргийлэх, нэгэнт хэрэглэдэг болсон хүүхэд, залуучууд, эмэгтэйчүүдийн зан үйлийг өөрчлөх сургалт явуулж, хорт зуршлаас нь ангижруулах.</p> <p>3. Мансууруулах бодис хэрэглэгчдийн дунд хор хөнөөлийг бууруулахад чиглэсэн хөтөлбөр, эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, зүү тариур дамжуулан хэрэглэхийг зогсоох, ХДХВ/ДОХ/БЗДХ-оос урьдчилан сэргийлэх сургалт явуулж, ХДХВ-ийн сайн дурын зөвөлгөө шинжилгээнд хамруулж, зан үйлийг өөрчлөх сургалтууд явуулж, НА бүлэг зохион байгуулж, сэтгэл зүйн зөвлөгөө өгч, хар тамхины хор хөнөөлийн талаархи мэдлэг боловсрол олгон, улмаар хэрэглэхээс татгалздаг болгох.</p>
Япон болон олон улсын хамтын ажиллагаа	<p>1999 онд байгуулагдсан цагаас</p> <p>*2000 онд Япон улсын ЭСЯ-тай хамтран ажиллаж, “Өвсний үндэс” хөтөлбөрөөр 16739 ам. долларын төсөл хэрэгжүүлсэн. Энэ төслөөр техник, тоног төхөөрөмж авч, үйл ажиллагааг чадавхижуулсан.</p> <p>* Монгол-Австралийн хөгжлийн хамтын ажиллагааны хөтөлбөр SAS,</p> <p>* ДЭМБ-ын дэмжлэгээр PAF төсөл,</p> <p>*НҮБ-ын UNODC санхүүжилтээр “Мансууруулах бодисгүй Монгол орон” нэртэй DAPC төсөл,</p> <p>* ЭМЯ, Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, Сүрьеэгийн төсөл,</p> <p>*ХЗДХЯ, ГХУСА33, НЭМГ, МОНЭС, Австралийн Хөгжлийн Хамтын Ажиллагааны САВ, SAFтөсөл,</p> <p>* ЭМЯ,ЭМДС, НИТХ, ГХУСА33, НЗДТГ сургагч бэлдэх төсөл,</p> <p>*НҮБХАС, НҮЭМ-ТББ сүлжээ, АДРА ОУБ, МГБССНийгэмлэг, ЦЕГ зэрэг байгууллагуудын санхүүжилтээр 51 төсөл хөтөлбөр хэрэгжүүлсэн.</p>
ЖАЙКА-тай хамтарсан төсөл, хөтөлбөр	



Санрайз халфвэй хаус халамж үйлчилгээний төв

Байгууллагын нэр	Санрайз халфвэй хаус халамж үйлчилгээний төв нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага
Байгуулагдсан он	2014 он
Хаяг	Баянгол дүүрэг, 2 дугаар хороолол, Энхтайвны өргөн чөлөө 4 дүгээр хороо 3-55
Утасны дугаар	91918132
E-mail	tumee_b2000@yahoo.com
URL/Facebook	Донтох эмгэгийн мэдээлэл
Төлөөлөгчийн нэр	Б.Түмэндэмбэрэл
Үйл ажиллагааны товч танилцуулга	<p>Дэлхий эрүүл мэндийн байгууллага болон НҮБ-ын Мансууруулах бодисын хор хөнөөлтэй тэмцэх албаны бодлого, Монгол Улсын Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль, Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуулийг тус тус чиглэл болгон төрийн захиргааны ба олон улсын ижил төстэй үйл ажиллагаатай байгууллагуудтай хамтран ажиллаж байна.</p> <p>Бид дараах зорилтуудыг дэвшүүлэн үйл ажиллагаа явуулж байна. Үүнд:</p> <p>1.Хүн амд үзүүлэх донтох эмгэгийн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, чанарыг сайжруулах;</p> <p>-Архи, тамхи, мансууруулах бодисын хамааралтай хүмүүст нийгэм-сэтгэл зүйн тусламж, зөвлөгөө үйлчилгээ үзүүлэх зөвлөгч бэлтгэх сургалтуудыг зохион байгуулж байна. Энэхүү зорилтын хүрээнд 400 гаруй зөвлөгч бэлтгэсэн.</p> <p>-Орон гэргүй архинд донтсон иргэдэд сэтгэл зүйн тусламж үйлчилгээ үзүүлэх ажлыг зохион байгуулж байна.</p> <p>2.Хүн амд сэтгэцийн болон донтох эмгэгийн эрүүл мэндийн боловсрол олгох замаар тэдгээрийн мэдлэгийн түвшинг нэмэгдүүлэх, урьдчилан сэргийлэх;</p> <p>-Хүүхэд, залуучуудын дунд архи, тамхи, мансууруулах бодисоос урьдчилан сэргийлэх танин мэдэхүйн сургалт явуулах, нэвтрүүлэг бэлтгэн нийтийн хүртээл болгох ажлыг зохион байгуулж байна.</p> <p>3.Донтох эмгэгтэй хүмүүст үзүүлэх нийгмийн халамж үйлчилгээний системийг боловсронгуй болгох, сайжруулах;</p> <p>-Шийдвэр гаргах болон бодлого боловсруулах түвшингийн хүмүүст тухайн асуудлаар мэдээлэл хүргэх, эрх зүйн орчинг бүрдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг явуулж байна.</p> <p>-Донтох эмгэгийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Америк нэгдсэн улс болон Япон улсын төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллаж тэдгээрийн туршлагыг өөрийн оронд нэвтрүүлэхээр зорилго тавин ажиллаж байна.</p>
Япон болон олон улсын хамтын ажиллагаа	<p>2007 онд Осака хотод байрлах MAC (Mary knoll Alcoholic Center) төрийн бус байгууллагын үйл ажиллагаатай танилцах завшаан тохиосон. Донтох эмгэгтэй хүмүүсийг эдгэрүүлэх нийгмийн халамжийн тогтолцоотой танилцаж өөрийн эх оронд нэвтрүүлэх хүсэл төрсөн юм. Тэр цагаас хойш ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг Япон улсын төрийн бус байгууллагуудтай холбогдох болсон.</p> <p>2018 онд Ёокохама хотод байрлах RDP (Recovery Dynamic Program Yokoyama) хөтөлбөрийг хэрэгжүүлэгч төрийн бус байгууллагын үйл ажиллагаатай танилцаж туршлага судалсан.</p> <p>2021 оноос Ёокохама хотод байрлах Y-ARAN төрийн бус байгууллагатай хамтран ажиллаж эхлээд байна.</p>
ЖАЙКА-тай хамтарсан төсөл, хөтөлбөр	Өнөөгийн байдлаар ЖАЙКА-тай хамтарсан ямар нэг төсөл, хөтөлбөрт оролцоогүй байна.



Монголын зөгийчдийн нийгэмлэг

Байгууллагын нэр	Монголын зөгийчдийн нийгэмлэг
Байгуулагдсан он	1991 он
Хаяг	Баянзүрх дүүрэг, 25-р хороо, Маргад хотхон 1 тоот
Утасны дугаар	90111141
E-mail	Ttuya24@gmail.com
URL/Facebook	https://www.facebook.com/MongolianBeekeepersAssociation
Төлөөлөгчийн нэр	Туяа
Үйл ажиллагааны товч танилцуулга	Зөгийчид болон зөгийн аж ахуй эрхлэж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллага хамт олны эрх ашгийг хамгаалан, амьдралын түвшинг баталгаатай болгоход туслан дэмжих, шинжлэх ухааны ололт, практикийг хослуулан зөгийн аж ахуйг хөгжүүлэх үйл ажиллагааг дэмжин ажилладаг.
Япон болон олон улсын хамтын ажиллагаа	Японы ХАА-н ба ойн аж ахуйн олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг "JAICAF", BeeDeer-Mongol I.II
ЖАЙКА-тай хамтарсан төсөл, хөтөлбөр	Байхгүй

БИДНИЙ ТУХАЙ



Монгол оронд "нисдэг сүрэг" суурьшин, үр шимээ өгч эхэлснээс хойш бараг хорь шахам жилийн дараа буюу 1977 онд зөгийчдийн анхны байгууллага болох "Залуу зөгийчдийн холбоо" байгуулагджээ. 1991 онд Сэлэнгэ аймгийн Шаамар суманд болсон Зөгийчдийн зөвлөгөөнд оролцогчдын саналаар "Монголын зөгийчдийн нийгэмлэг"-ийг үүсгэн байгуулсан.

2003 онд болсон зөгийчдийн төлөөллийн хурлаар "Монголын зөгийчдийн нийгэмлэг"-ийн ерөнхийлөгчөөр Г.Очирбат, Гүйцэтгэх захирал, хэвлэл мэдээллийн эрхлэгчээр Х.Отгонбилэг нар ажилласан. 2013 оны 4-р сард Монголын Зөгийчдийн III чуулганаа зохион байгуулж Нийгэмлэгийн дүрмийг зарим нэмэлт өөрчлөлт оруулж, удирдах зөвлөлийн 11 гишүүдийн бүрэлдэхүүнтэй, ерөнхийлөгчөөр Ц.Туваанг сонгож, гүйцэтгэх захирлаар Т.Уугаг томилон ажилдуулж байна.

Өдгөө Гүйцэтгэх захирлын ажлын албаны "Мэргэжлийн зөвлөх баг" нь зөгийн аж ахуйн мэргэжилтэн, эрдэмтэн, докторуудаас бүрдсэн 20 гишүүнтэй үйл ажиллагаа явуулж байна.

Монголын Зөгийчдийн Нийгэмлэг нь зөгийн мэргэжилтэн ба зөгийчдийг сургах, хөгжүүлэх, зөвлөгөө өгөх, Зөгийн аж ахуйн бүтээгдэхүүн, зөгийн тэжээлийн талаар зөвлөмж, лавлах, ном товчлол, эрдэм шинжилгээний өгүүллэгийг нийтлүүлэх, судалгаа ба эрдэм шинжилгээний чиглэлээр дотгоод болон ОУ байгууллагуудтай хамтрах, кластер хөгжүүлэх, түүнчлэн, зөгийн аж ахуй эрхлэгдэд санхүүгийн дэмжлэг олох зэрэг олон талт ажлуудыг хийдэг.

АЛСЫН КАРАА

Монголын Зөгийчдийн Нийгэмлэг нь эх орныхоо онгон байгалийг зөгийн аж ахуйгаар дамжуулан ирээдүй хойч үедээ өвчүүлэн үлдээхэд тэргүүлэгч байгууллага байна.



ЭРХЭМ ЗОРИЛГО

Монголын Зөгийчдийн Нийгэмлэг нь гишүүдийнхээ эрх ашгийг дээдэлэн, шинжлэх ухаанд суурилсан мэдлэгээр чадавхижуулж, чанар стандартад нийцсэн зөгийн бүтээгдэхүүнийг Дэлхийд таниулахад дэмжиж ажилладаг, менежмент, санхүүгийн бие даасан байгууллага байна.



ҮЙЛЧИЛГЭЭ БА ХӨНГӨЛӨЛТ

ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨРӨЛ		Зөгийн гишүүн	Бүрэн эрхтэн гишүүн
1	Сургалтын чиглэлээр	10%	20%
1.1	"Зөгийчин" гэрчилгээ олгох сургалт	✓	✓
1.2	Бизнес хөгжлийн сургалт	✓	✓
1.3	"Зөгийн аж ахуйн захистой дадал нэвтрүүлэх" сургалт	✗	✓
1.4	"Органик зөгийн аж ахуйн" сургалт	✗	✓
2	Зөгийн аж ахуйн бизнесээ өргөжүүлэх, хамтран ажлахаа чиглэлээр		
2.1	Зөгийн аж ахуйтай танилцаж туршилага судлах агаал	✓	✓
2.2	МЭН гишүүнчлэлийн уулзалт	✓	✓
2.3	Дэлхийн зөгийчдийн их хуралд оролцох (APIMONDIA)	✗	✗
3	Зөгийн аж ахуйгаа сурталчлах		
3.1	МЭН-ын вебсайтад гишүүн, бүтээгдэхүүний мэдээлэл оруулах	✓	✓
3.2	Зөгий-фэйс-бк-сэтгүүлд сурталчилгаа нэвтрүүлэх	✗	✓
3.3	Зөгийн балны баяр үзэсгэлэн худалдаа	✗	✓
3.4	ОУ-ын үзэсгэлэн худалдаа	✗	✓
4	Мэдээлээр хяналт чиглэлээр		
4.1	2 цагийн зөвлөх үйлчилгээ	✓	✓
4.2	Монголын зөгийн аж ахуйн нэг тээлийн талаархи судалгааны үр дүн, мэдээлэл	✗	✓
4.3	ОУ-ын зөгийн аж ахуйн судалгааны үр дүн, мэдээлэл	✗	✗
5	Зөвлөх үйлчилгээний чиглэлээр	10%	20%
5.1	Зөгийн бүсийн орчлонга мэдээлэл	✓	✓
5.2	Зөгийн эрүүл мэнд	✓	✓
5.3	Зөгийн бэлчээр, бэлт урсгал	✓	✓
5.4	Зөгийн аж ахуйн бизнес тогтолцоо	✗	✓
5.5	Зөгийн аж ахуйн захистой дадал нэвтрүүлэх	✗	✓
5.5	Органик зөгийн аж ахуй	✗	✓

БИДНИЙ ХИЙСЭН АЖИЛ

1. Бодлого, омгоолод, бизнес хөгжлийн чиглэлээр:

- 2014 онд ХХААХУЯам, Дэлхийн Зон ОУБ -тай хамтын ажиллагааны санамж бичигт гарын үсэг зурсан.
- 2015 оноос Монгол зөгийн балны гарал үүсэл чанар стандартын хангуулах тал дээр Улсын мал эмнэлэг ариун цэврийн төв лаборатори хамтран ажиллаж байна.
- 2015 оноос "JAICAF" ОУБ-тай хамтран зөгийн аж ахуйн технологи дамжуулах төслийг хэрэгжүүлсэн
- 2015 оноос Монгол улсад зөгийн аж ахуйн кластерийг хөгжүүлэх, зөгийн аж ахуйн нэгжүүдийн чадавхийг нэмэгдүүлэх, зөгийн балны үйлдвэрлэл, борлуулалтыг дэмжих зорилгоор "Аравт бизнес нэгдэл" ТББ, "Гайгурт" ХХК-тай хамтран ажиллаж байна.
- 2016 онд Органик хүнсний тухай хуулийн ажлын хэсэгт ажиллаж, Органик зөгийн аж ахуйн эсүүрийг батлуулсан.
- 2016 оноос Дэлхийн Зөгийчдийн Холбоо болох Apimondia ОУБ-д гишүүнээр элсэн.
- 2017 оноос Зөгийн аж ахуйн нэмүү өртгийн сүүжээг бий болгох АХБ-ын төслөө санхүүжилт босгосон.
- 2017 оноос Европын сэрэгэн босголт хөгжлийн банкны санхүүжилтаар Жижиг Бизнесийн Санаачлага хөтөлбөрийн "Монголд үр дүнтэй, бизнес гишүүнчлэлтэй байгууллагуудыг хөгжүүлэх" төсөл хэрэгжэж байна.

Сургалт, хөгжил, зөвлөгөө чиглэлээр:

- 2013 онд ОХУ-ын Башкир улсын "Зөгийн эрдэм шинжлэлийн судалгааны төв"-тэй ялт хамтын ажиллагаатай ажиллаж туршилага салчихоох агаал зохион байгуулсан.
- 2014 оноос Сэлэнгэ аймгийн Шаамар суман дахь МСУТов болон Ходолморийн яамтай хамтран Зөгийн аж ахуйн сургалтын хөтөлбөр боловсруулсан.
- 2014 онд Турк улсад Азийн зөгийн аж ахуйн холбооны багс хуралд оролцов.
- 2014-2016 онд НҮБ-ийн Хүнс ХАА Байгууллагын Огно-Огноодийн хамтын ажиллагааны төслийн хүрээнд зөгийчдэд багс лэгуур, тусгаарлах төр, сэмжээр ханган ажилласан.
- 2015 онд Солонгос улсын Даежеон хотноо болсон "Apimondia-44" их хуралд төлөөлөгчид оролцуулсан.
- 2017 онд Турк улсын Истанбул хотод "Apimondia-45" их хуралд оролцов.
- 2018 оноос Боловсролын үнэлгээний төвтэй хамтран зөгийчин мэргэжлийн сургалтын үнэлгээг тогтоох судалгааны ажлыг явагдаж байна.

2. Чуулган, семинар, аяны чиглэлээр:

- 2013 онд Монголын Зөгийчдийн III чуулган
- 2014 онд Зөгийчдийн Удирдах ажилтны семинар
- 2015 онд "Гайхамшигийн хамтдаа бүтээе" симпозиум
- 2015 онд "Зөгийн аж ахуйн зөвлөхүүдийн бэлтгэх" сургалт
- 2016 онд "Халбага зөгийн багс аян"
- 2017 онд "Зөгийн балны баяр"
- 2018 онд "Монголын Зөгийн аж ахуйн Кластерийн хөгжлийн"

ХАМТРАН АЖИЛЛАЖ БҮЙ БАЙГУУЛЛАГУУД



ОРОЛЦСОН ОЛОН УЛСЫН ИХ ХУРЛУУД



ХОЛБОО БАРИХ



"МОНГОЛЫН ЗӨГИЙЧДИЙН НИЙГЭМЛЭГ" ТББ

Дэлхийг тэтгэх зөгий



ДЭЛХИЙН ЗӨГИЙЧДИЙН ХОЛБООНЫ ГИШҮҮН БАЙГУУЛЛАГА

Монголын хөдөө аж ахуйн дэвшил холбоо

Байгууллагын нэр	Монголын хөдөө аж ахуйн дэвшил холбоо
Байгуулагдсан он	2015 он
Хаяг	Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Шаравын 32р байрны 2-194 тоот
Утасны дугаар	99187266,89993006
E-mail	Jangaa.d89@gmail.com
URL/Facebook	https://www.facebook.com/groups/1684093911805719
Төлөөлөгчийн нэр	Д.Жанцанхорол
Үйл ажиллагааны товч танилцуулга	<p>Монголын хөдөө аж ахуйн дэвшил холбоо нь 2015 оны 8 дугаар сарын 12-ны өдөр байгуулагдсан нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага юм.</p> <p>Монголын Хөдөө аж ахуйн Дэвшил Холбооны гишүүдийн 54,2 хувь нь доктор, профессор, дэд профессор, 41,7 хувь нь магистр, зөвлөх зэрэгтэй, нийт гишүүдийн 91,7 хувь нь салбарын яам, агентлаг, сургалт-эрдэм шинжилгээний байгууллага, олон улсын байгууллагын төсөл хөтөлбөр, төрийн бус байгууллагад удирдах алба хашиж байсан буюу одоо ажиллаж байгаа, 8,3 хувь нь хувийн хэвшилд ажилладаг мэдлэг туршлага, мэргэжлийн ур чадвар сайтай хүмүүс юм.</p> <p>Монголын хөдөө аж ахуйн дэвшил холбооны Ерөнхийлөгчөөр төр нийгмийн зүтгэлтэн Д.Тэрбишдагва, Удирдах зөвлөлийн даргаар Зөвлөх мал зүйч Д.Жанцанхорол, Гүйцэтгэх захирлаар нягтлан бодогч, эдийн засагч С.Юндэндорж ажилладаг. Холбооны удирдах зөвлөл нь мал аж ахуй, газар тариалан, хүнсний салбарыг төлөөлсөн 7 гишүүнтэй.</p> <p><u>Монголын Хөдөө аж ахуйн дэвшил холбооны зорилго:</u></p> <p>Хөдөө аж ахуй, хүнсний үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололт, гадаад, дотоодын дэвшилтэт арга технологийг нэвтрүүлэх, уламжлалт бэлчээрийн мал аж ахуй, байгаль орчинд ээлтэй газар тариаланг эрчимжсэн аж ахуй, хүнсний үйлдвэрлэлтэй зохистой хослон хөгжүүлэх, органик хүнсний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, хөдөө аж ахуй, хүнсний салбарын хөгжлийн гарцыг тодорхойлоход бодлогын зөвлөгөө өгөх.</p> <p><u>Монголын Хөдөө аж ахуйн дэвшил холбооны үйл ажиллагааны үндсэн чиглэл:</u></p> <ul style="list-style-type: none"> • Мал аж ахуй, газар тариалан хүнсний салбарт дэвшилтэт арга технологи, биотехнологийн ололтыг нэвтрүүлэх ажлыг сургалт-эрдэм шинжилгээний байгууллагатай хамтран хэрэгжүүлэх; • Байгаль орчинд ээлтэй хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, бүтээгдэхүүн нийлүүлэлтийг хоршин хөгжүүлэхэд мэргэжлийн туслалцаа үзүүлэх; • Монгол орны бэлчээрийн мал аж ахуй, нүүдлийн соёл иргэншилтэй уялдан бий болсон уламжлалт хоол, хүнсийг судлах, түүний үнэт чанар, давуу талыг гадаад, дотоодод сурталчлан таниулах; <p>Хөдөө аж ахуй, хүнсний салбарын үйлдвэрлэл эрхлэгчдэд зориулсан мэдлэг түгээх, туршлага солилцох сургалт семинар, танилцах аялал зохион байгуулах.</p>
Япон болон олон улсын хамтын ажиллагаа	Байхгүй
ЖАЙКА-тай хамтарсан төсөл, хөтөлбөр	Байхгүй



ЖАЙКА-гийн сургалт төгсөгч, Сэлэнгэ аймгийн Баянгол сумын тариалан эрхлэгч, Улсын тэргүүний тариаланч Ц.Зундуй ЖАЙКА-гийн сургалт төгсөгчдийн холбоотой хамтран зохион байгуулсан сургалт дээр “Хүнсний ногоо тариалах, хадгалах, тээвэрлэх, борлуулах туршлага, үр дүн” илтгэл тавив. Улаанбаатар хот, 2019.11.19.



Доктор Х.Алтангэрэл Япон Улсад ЖАЙКА-гийн сургалтад оролцож “Орон нутаг дахь ноолуурыг худалдан авах тогтолцоог сайжруулах нь” илтгэл тавьсны дараа.
(Баруун гараас эхнийх нь) Обихиро хот. 2020.01. 18.

Монголын жимс жимсгэний үндэсний холбоо

Байгууллагын нэр	Монголын жимс жимсгэний үндэсний холбоо
Байгуулагдсан он	2016 он
Хаяг	Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, АЗМОН төв 503 тоот
Утасны дугаар	70156339, 99116339
E-mail	mongolfruits@gmail.com
URL/Facebook	https://www.facebook.com/mongolfruits/
Төлөөлөгчийн нэр	Тэргүүн Д.Насанжаргал
Үйл ажиллагааны товч танилцуулга	<p>Бид Монгол оронд чацаргана бусад жимс жимсгэний тариалалтыг өргөтгөх, байгалийн чацаргана, жимс жимсгэний нөөцийг хамгаалах, жимс жимсгэнэ болон бусад түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэл, технологийг хөгжүүлэх, шинжлэх ухааны үндэслэлтэй судалгааг гүнзгийрүүлэх үндсэн дээр хүн амын хүнсэн дэх жимс жимсгэнэ, түүний гаралтай бүтээгдэхүүний хангамжийг нэмэгдүүлэх, улмаар эдгээр бүтээгдэхүүнийг гадаад зах зээлд гаргах үйл ажиллагааг далайцтай, үр бүтээлтэй өрнүүлэхэд төр засгийн болон хувийн хэвшлийн байгууллага, гишүүд дэмжигчидтэйгээ хамтран ажиллаж, тэдэнд үйлчлэхэд оршино.</p> <p>2010 оноос хойш сургалт, судалгаа, уулзалт, үзэсгэлэн, хурал зөвлөлгөөн зэрэг олон талт арга хэмжээнд 15000 шахам иргэдийг хамруулан нүүр тулан ажиллаж ирсэн болно.</p> <p>Засгийн газрын “Чацаргана” үндэсний хөтөлбөрийн төслийг боловсруулан салбарын яаманд санал болгон баталгаажуулсны дагуу уг хөтөлбөрийг 2010-2016 онд хамтран хэрэгжүүлж түүний үр дүнд жимс жимсгэний тариалалт 6000 гаруй га, хураан авах ургац жил бүр 2500-3500 тонн болж өслөө.</p> <p>Цаашид салбарыг тогтвортой хөгжлүүлэх бодлого, арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх зорилгоор салбарын яамтай хамтран мөн Засгийн газрын “Жимс жимсгэнэ” үндэсний хөтөлбөрийг боловсруулан батлуулж 2018-2022 онд хэрэгжүүлэхээр ажиллаж байна.</p> <p>Жимс жимсгэний салбарын стандарт, техник технологийн баримт бичгүүд шинэчлэх, шинээр боловсруулан батлуулж мөрдүүлэхэд анхаарч төрөл бүрийн жимс жимсгэний суулгацын болон зах зээлд нийлүүлэх жимс жимсгэнэ, тэдгээрийн бүтээгдэхүүний нийт 22 үндэсний стандартыг эрдэмтэн, мэргэжилтнүүдийн багаар боловсруулан мэргэжлийн байгууллагуудаар баталгаажуулан мөрдүүлэн ажиллаж байна.</p>
Япон болон олон улсын хамтын ажиллагаа	Тус холбоо нь ОУ-ын Чацарганы холбоо /2011 оноос/, ОУ-ын Таримал ургамлын нийгэмлэг /2017он/-ийн гишүүн болж үйл ажиллагаанд нь тогтмол оролцож байна. Түүнчлэн ОХУ, БНХАУ, ХБНГУ, Япон, БНСУ, Тайвань зэрэг гадаад орны эрдэм шинжилгээ, бизнесийн байгууллагуудтай өргөн харилцаа холбоо тогтоон ажиллаж байгаа юм.
ЖАЙКА-тай хамтарсан төсөл, хөтөлбөр	Байхгүй



Зураг 1. Чацарганы тариалан



Зураг 2. Чацарганы бүтээгдэхүүн



Зураг 3. ОУ-ын Чацарганы холбооны VII чуулганы үеэр. БНХАУ. 2019 он



Зураг 4. Монголын чацарганы кластерийн анхдугаар чуулган. 2020 он

Монголын хүлэмжийн аж ахуй эрхлэгчдийн холбоо

Байгууллагын нэр	Монголын хүлэмжийн аж ахуй эрхлэгчдийн холбоо ТББ
Байгуулагдсан он	2012 он
Хаяг	Сонгино-хайрхан дүүрэг, 19-р хороо, 21-р хороолол, Үйлдвэрчний эвлэлийн гудамж, ЭХ 2-14
Утасны дугаар	99131692
E-mail	khulemjkhoolboo@yahoo.com
URL/Facebook	Монголын хүлэмжийн аж ахуй эрхлэгчдийн холбоо ТББ
Төлөөлөгчийн нэр	Төрийн бус байгууллагын тэргүүн Я.Оюунчимэг /PhD/
Үйл ажиллагааны товч танилцуулга	<p>Тус ТББ нь 2012 онд албан ёсоор байгуулагдсан бөгөөд хүлэмжийн аж ахуй эрхлэгчдийн эрх ашгийг хамгаалах, сургалт явуулах, зөвлөх үйлчилгээг өгөх зэрэг үйл ажиллагааг тасралтгүй явуулж ирсэн. Бид Монгол Улсын 21 аймаг, Улаанбаатар хотын 6-н дүүргийн хүлэмжийн аж ахуй эрхлэгч аж ахуй нэгж, хоршоо, бүлгийн 1500 гаруй гишүүдэд “Хүлэмжийн төрлүүд, тэдгээрт нарийн ногоо, жимс жимсгэнэ тариалах агротехнологи” сэдэвт онол, дадлагын сургалт, зөвлөх үйлчилгээг жил бүр үзүүлж ирсэн.</p> <p>Түүнчлэн тус холбоо нь Хүнс Хөдөө Аж Ахуй Хөнгөн Үйлдвэрийн Яам, Хөдөө Аж Ахуйн Их Сургууль, Ургамал газар тариалангийн хүрээлэн -тэй хамтран “Хүлэмжийн аж ахуйн үйлдвэрлэлийн хөгжил, тулгамдаж буй бэрхшээл, гарц шийдэл” хэлэлцүүлэгийг зохион байгуулж, хэлэлцүүлгээс гарсан зөвлөхийг ХХААХҮЯам болон Засгийн газарт хүргүүлэн төрийн бодлогод аж эрхлэгчдийн дуу хоолойг хүргэх, тэдгээрийн үйл ажиллагааг дэмжсэн бодлого шийдвэр гаргахад нь туслаж ирлээ.</p> <p>Энэ хүрээнд 2016 онд ХХААХҮЯ-ны захиалгаар “Өвлийн халаалттай нийлэг хальсан хүлэмж” MNS 6637:2016, “Зуны нийлэг хальсан хүлэмж” MNS 6636:2016 стандартыг тус тус боловсруулж, батлуулан үйлдвэрлэлд нэвтрүүлээд байна.</p>
Япон болон олон улсын хамтын ажиллагаа	Японы ЖАЙКА, БНСУ-ын Койка, Голланд Улсын “ENZA ZAIDAN CO.,LTD” үрийн компани, Швейцарийн Хөгжлийн Агентлаг, Германы Хамтын Ажиллагааны нийгэмлэг
ЖАЙКА-тай хамтарсан төсөл, хөтөлбөр	ЖАЙКА ОУБ-тай хамтран “Монгол Улсын хөдөө аж ахуйн нэмүү өртгийн сүлжээний мастер төлөвлөгөө боловсруулах” төслийн хүрээнд Япон Улсын TAKII & CO.,LTD өргөст хэмх, лооль, сонгины үрийг хүлэмжийн үйлдвэрлэлд туршиж байна.

Монгол Ви.И.Ти.НЕТ

Байгууллагын нэр	Монгол Ви.И.НЕТ ТББ /Mongolia V.E.T Net NGO/
Байгуулагдсан он	2003 он
Хаяг	Хан-Уул дүүрэг, 2-р хороо, 145/5
Утасны дугаар	99073412
E-mail	tsek@vetnetmn.org
URL/Facebook	vetnetmn.org
Төлөөлөгчийн нэр	Tserendorj L /Мал эмнэлгийн хэлтсийн дарга, малын их эмч/
Үйл ажиллагааны товч танилцуулга	<p>Монгол Ви.И.Ти Нет ТББ нь 1998 оноос Жей-Си-Эс ОУБ-н “Вэт Нэт” буюу “Мал Эмнэлгийн Сүлжээ” төсөл нэртэйгээр анх үүсэн байгуулагдсан. Анх Архангай, Өвөрхангай аймгуудад хувьчлагдсан мал эмнэлгийг дэмжих, алслагдсан хөдөө орон нутгийн сургууль болон дотуур байрны хүүхдүүдэд сургалт, төсөл хэрэгжүүлэх замаар үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн.</p> <p>Улмаар 2003 онд төрийн бус байгууллага болж Хууль Зүйн Яаманд албан ёсоор бүртгүүлсэн. Тус байгууллага нь 80 монгол ажилтантай, 4 гадаад зөвлөх мэргэжилтэнтэй, 5 хэлтэстэй үйл ажиллагаагаа Монгол улсын хэмжээнд явуулж байна. Одоогоор,</p> <ol style="list-style-type: none"> 1. Мал эмнэлгийн чиглэлээр: Мал Эмнэлгийн Үргэлжилсэн Сургалт Хөтөлбөр /21 аймаг хотын малын эмч нар/, малын эм хэрэгсэлийн импорт, Жижиг болон Том амьтны эмнэлэг сургалтын төвүүд, Мал эмнэлгийн сургуулийн оюутнуудын клубууд, Дадлагажигч малын эмч хөтөлбөр, Хурдан морь сургалт семинар, Малчны сургалтууд 2. Боловсрол Хүмүүнлэгийн чиглэлээр: Хөдөө орон нутгийн хүүхдүүдэд зориулсан Зуны сургалтууд, Зан чанар ёс зүйн сургалтууд, Англи хэлний сургалтын төв, Ядуу өрхүүдэд “Хайрын бэлэг” төсөл бусад орон нутгийн байгууллагуудтай хамтарсан төслүүд
Япон болон олон улсын хамтын ажиллагаа	Байхгүй
ЖАЙКА-тай хамтарсан төсөл, хөтөлбөр	

Хүний эрх хөгжил төв

Байгууллагын нэр	Хүний эрх хөгжил төв
Байгуулагдсан он	1998 он
Хаяг	Чингэлтэй дүүрэг, 3-р хороо, энхтайвны өргөн чөлөө-54, Пийс тауэр 11 давхар, 1103 тоот
Утасны дугаар	325721,319037
E-mail	chrd@mongolnet.mn
URL/Facebook	https://www.facebook.com/chrd.mongolnet
Төлөөлөгчийн нэр	Тэргүүн Г.Уранцоож, Гүйцэтгэх захирал У.Мандхайцэцэн
Үйл ажиллагааны товч танилцуулга	Тус байгууллага нь орон нутгийн иргэдийн шийдвэр гаргахад оролцох, хэрэгжилтийг хянах, үнэлэх, хариуцлага тооцдог болох хамтын чадавхийг хөгжүүлэхэд дэмжин ажилладаг. Дараах 3 чиглэлээр ажилладаг. <ol style="list-style-type: none"> 1. Хүний эрхийн нөлөөллийн хөтөлбөр 2. Хүний эрхийн хамгааллын хөтөлбөр 3. Хамт олонд суурилсан хөгжлийн хөтөлбөр
Япон болон олон улсын хамтын ажиллагаа	Япон – JANIC, Солонгос –ADA, Тайланд-FA, PANAP, RoA, CPDE, ANNI, IBON
ЖАЙКА-тай хамтарсан төсөл, хөтөлбөр	Одоогоор байхгүй



Хүйсийн тэгш эрх төв

Байгууллагын нэр	Хүйсийн тэгш эрх төв НҮТББ
Байгуулагдсан он	2002 он
Хаяг	Чингэлтэй дүүрэг, 5-р хороо, Виктори төв, 4 давхар, 404 тоот
Утасны дугаар	311512
E-mail	gendereqcen@magicnet.mn, mongoliangenderequalitycenter@gmail.com
URL/Facebook	Mongolian Gender Equality Center/ Хүйсийн тэгш эрхийн төв
Төлөөлөгчийн нэр	Г.Ганбаясгах
Үйл ажиллагааны товч танилцуулга	<p>Хүйсийн тэгш эрх төв нь жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр олон талт үйл ажиллагаа явуулдаг нийгэмд үйлчилдэг ТББ юм.</p> <p>Тус төв нь хохирогч хамгаалал, урьдчилан сэргийлэх, нөлөөллийн үйл ажиллагааны 3 хөтөлбөртэй.</p> <p>Бид 2002 оны 1 сарын 4-нд байгуулагдсан цагаасаа эхлэн бэлгийн хүчирхийлэл, хүчингийн гэмт хэргийн хохирогчдод туслалцаа үзүүлэх үйлчилгээг, ХХГХ-ийн хохирогчдод туслалцаа үзүүлэх үйлчилгээг 2003 оноос, эх оронд нь аюулгүйгээр эгүүлэн авчрах, анхан шатны туслалцаа дэмжлэг үзүүлэх, эргэн нийгэмшүүлэх, нөхөн сэргээх ажлыг 2007 оноос, хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор 24 цагийн үйлчилгээтэй 1903 итгэлийн утасны үйлчилгээг 2006 оноос тус тус ажиллуулж байна.</p> <p>Өнгөрсөн хугацаанд нийт 2000 орчим хүнд туслалцаа үзүүлэн ажилласны 742 нь (2019.03.31) нь хүний наймааны хохирогчид, 189 хүчин, бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхэд байлаа. Хохирогчдын 73% нь эмэгтэйчүүд, 11% нь хүүхэд, 70% нь бэлгийн, 25,8% нь хөдөлмөр мөлжлөгийн хохирогчид бөгөөд тэдний 2 хүн тутмын 1 нь БНХАУ-д, 4 хүн тутмын 1 нь эх орон дотроо худалдагдсан үйлчлүүлэгчид байна.</p> <p>Гадаадын 9 улсаас 286 хохирогчийг эх орондоо эгүүлэн авчирсан бол, гадаад улсын 8 хохирогчийг эх оронд нь буцаахад туслалцаа үзүүлэн ажилласан.</p> <p>Тус төв нь Улаанбаатар хотод 6 ортой, Замын-Үүдэд 3 ортой хамгаалах байртай бөгөөд хохирогчийг 1 хоногоос 3 сар хүртэл байрлуулах боломжтой. 2007 оноос хойш хохирогчдын 361 нь Улаанбаатар хотын, 164 нь Замын-Үүд дэх түр хамгаалах байранд дунджаар нэг хүн 30 хоног байрласан байна.</p> <p>Цагдаагийн байгууллагад 424 хохирогчийн 232 хэргийн асуудлаар хандаж, шүүхээр 129 хохирогчтой 47 хэргийг өмгөөллийн туслалцаа үзүүлж, шийдвэрлүүлсэн байна.</p> <p>Тус төв нь итгэлийн утсанд хандсан 9642 дуудлагын дагуу мэдээлэл зөвлөгөө өгч, хүчирхийлэл, хүний наймааны хохирогч 2000 орчим хүнд хамгаалах үйлчилгээ үзүүлж, 100 гаруй хохирогчтой 40 орчим хэргийг шүүхээр эцэслэн шийдвэрлүүллээ.</p> <p>2002 оноос хойш ХТЭТ нь хууль сахиулах байгууллагын ажилтнууд, ТББ-ууд, мэргэжлийн бүлгүүдийн 250,000 орчим оролцогчдод 200 гаруй сургалт зохион байгуулсан.</p>
Япон болон олон улсын хамтын ажиллагаа	Байхгүй
ЖАЙКА-тай хамтарсан төсөл, хөтөлбөр	Байхгүй

Түгээмэл эрх хөгжил

Байгууллагын нэр	Түгээмэл эрх хөгжил НҮТББ
Байгуулагдсан он	2014 он
Хаяг	Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Залуучуудын гудамж 9-Б01
Утасны дугаар	99088306
E-mail	saruul@urdinstitute.com
URL/Facebook	www.urdinstitute.com
Төлөөлөгчийн нэр	Т.Сапуул
Үйл ажиллагааны товч танилцуулга	<p>“Түгээмэл Эрх Хөгжил” ТББ-г 2014 онд хүний эрхийн чиглэлээр судалгаа хийж мэргэшсэн хэсэг хуульч, судлаачид анх санаачлан үүсгэн байгуулсан.</p> <p>Байгууллагын эрхэм зорилго: Хүний эрх, эрх чөлөө, ардчилсан чөлөөт нийгмийн үнэт зүйл зарчмыг эрхэмлэн, хүний эрхийг хангах, хамгаалах, эрх зүйн үнэт зүйлсийг бэхжүүлэхэд өөрсдийн хувь нэмрийг оруулах. (Түгээмэл Эрх ТББ-ын дүрмийн 2.1 дүгээр зүйл).</p> <p>Бид эрхэм зорилгынхоо хүрээнд хараат бус судалгаа, сургалт, олон улсын хурал зөвлөгөөн зохион байгуулах, зөвлөх үйлчилгээ үзүүлэх, нийтийн эрх ашгийг хамгаалах стратегийн өмгөөлөл хийх чиглэлээр мэргэшсэн институц болох зорилт тавин ажиллаж байна.</p> <p>Бидний үйл ажиллагааны бас нэг онцлог тал нь урлаг соёлоор дамжуулан хүний эрхийг сурталчлах нөлөөллийн үйл ажиллагааг хөгжүүлэх явдал юм.</p>
Япон болон олон улсын хамтын ажиллагаа	ТЭХ ТББ нь байгуулагдсан цагаасаа хойш ОУ эрх зүй, хүний эрхийн чиглэлээр жилд нэгээс доошгүй удаа олон улсын болон үндэсний хэмжээний хурал, нөлөөллийн үйл ажиллагаанууд зохион байгуулж ирсэн.
ЖАЙКА-тай хамтарсан төсөл, хөтөлбөр	Байхгүй



Сайн дурынхны хөгжлийн төв

Байгууллагын нэр	Сайн дурынхны хөгжлийн төв НҮТББ
Байгуулагдсан он	2009 он
Хаяг	Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Бээжингийн гудамж, НУВ Инновацийн Төв, 2 давхарт 20Х тоот
Утасны дугаар	99019645
E-mail	Vdcenter.ngo@gmail.com
URL/Facebook	https://www.facebook.com/VolunteerDevelopmentCenter
Төлөөлөгчийн нэр	М.Бямбабат
Үйл ажиллагааны товч танилцуулга	<p>Анх Сайн дурынхны хөгжлийн төв нь 2009 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд идэвхитэй үйл ажиллагаа явуулаад 5 дахь жилдээ орж байна.</p> <p>Сайн дурынхны хөгжлийн төв нь хүүхэд, залуучууд руу голлон чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг бөгөөд манай байгууллагыг 15- 30 насны залуучууд удирдан ажиллаж байна.</p> <p>Байгууллага нь нийгмийн бүхий л салбарт ажиллах боломжтой сайн дурын ажилтнуудыг бэлтгэх, хөгжүүлэх, мөн тэдний оролцоотой нийгмийн хөгжилд хувь нэмрээ оруулах эрхэм зорилготой.</p>
Япон болон олон улсын хамтын ажиллагаа	Байхгүй
ЖАЙКА-тай хамтарсан төсөл, хөтөлбөр	Байхгүй



Монголын неврологийн нийгэмлэг

Байгууллагын нэр	Монголын неврологийн нийгэмлэг
Байгуулагдсан он	2014 он
Хаяг	Сүхбаатар дүүрэг, Багшийн дээдийн уулзвар, UBH Center, 3 давхар, 315 тоот
Утасны дугаар	99233332
E-mail	info@mongolianneurology.org
URL/Facebook	https://www.facebook.com/mongolianneurology/
Төлөөлөгчийн нэр	П.Соёлмаа
Үйл ажиллагааны товч танилцуулга	<p>Үйл ажиллагааны товч танилцуулга: Монголын Неврологийн нийгэмлэг нь Монголын мэдрэлийн эмч, багш, судлаач нарыг эгнээндээ багтаасан, тэдний мэдлэг ур чадвар, хамтын ажиллагааг бэхжүүлэх чиглэлээр сургалт, судалгааны ажлыг зохион байгуулдаг, гишүүддээ үйлчилж, тэдний эрх ашигт нийцсэн идэвхтэй үйл ажиллагаа бүхий төрийн бус байгууллага юм. Эгнээндээ 300 гаруй мэдрэлийн эмч нарыг багтаасан гишүүнчлэлтэй.</p> <p>Бидний эрхэм зорилго: Монголын мэдрэлийн эмч нарын мэдлэг, чадвар хүчийг нэгтгэх, дотоод гадаадын эмч нарын харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх замаар мэдрэлийн өвчний тусламж үйлчилгээг сайжруулах, Монгол улсын эрүүлмэндийн салбарын хөнжилд хувь нэмэр оруулахад оршино.</p> <p>Нийгэмлэгийн үндсэн үйл ажиллагааны чиглэл: Мэдрэлийн эмч нарт зориулсан төрөл бүрийн сургалт зохион байгуулах, мэдрэлийн тусламж үйлчилгээг сайжруулах төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, мэргэшлийн зэрэг олгох шалгалт авах, мэрэгжлийн сэтгүүл, гарын авлага гаргах, ХБНГУ, Япон, Солонгос зэрэг орон, олон улсын мэрэгжлийн нийгэмлэг холбоодтой хамтран ажиллах, судалгаа, эрдэм шинжилгээний ажил хийх, олон нийтэд чиглэсэн арга хэмжээнүүдийг зохион байгуулах зэрэг.</p>
Япон болон олон улсын хамтын ажиллагаа	Байхгүй
ЖАЙКА-тай хамтарсан төсөл, хөтөлбөр	Байхгүй



Сэтгэл судлалын үндэсний төв

Байгууллагын нэр	Сэтгэл судлалын үндэсний төв ТББ
Байгуулагдсан он	2010 он
Хаяг	Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Бизнес плаза 5 давхар 505 тоот
Утасны дугаар	77324233
E-mail	psychology.npc@gmail.com
URL/Facebook	https://www.facebook.com/NationalPsychologyCenter
Төлөөлөгчийн нэр	Б.Ууганцэцэг Гүйцэтгэх захирал
Үйл ажиллагааны товч танилцуулга	<p>Сэтгэл Судлалын Үндэсний Төв ТББ нь сэтгэл судлалын шинжлэх ухааныг хөгжүүлэх сурталчилан дэлгэрүүлэх, амьдралын өдөр тутмын хэрэглээнд нэвтрүүлэх зэрэг зорилгынхоо хүрээнд үйл ажиллагаагаа тогтвортой эрхэлж байгаа мэргэжлийн ууган байгууллагуудын нэг юм.</p> <p>Манай төв онол-практикийг хослуулан хувь хүн, хүүхэд, гэр бүл, байгууллагад сэтгэл зүйн үйлчилгээг хүргэн ажиллаж байна. Сэтгэл зүйн ганцаарчилсан болон бүлгийн зөвлөгөө, сэтгэл зүйн сургалт, судалгаа, нөлөөллийн ажил хийдэг.</p> <p>Олон нийтийн сэтгэл зүйн боловсролд зориулж сэтгэл зүйн ном бүтээл, мэргэжилтнүүдэд зориулсан гарын авлага боловсруулан хүргэдэг.</p> <p>Салбартаа танигдсан мэргэжлийн чадварлаг сэтгэл судлаачдаас бүрдсэн хамт олон юм.</p>
Япон болон олон улсын хамтын ажиллагаа	<p>Бид Дэлхийн зөн ОУБ, Good neighbors ОУБ, Каритас Монгол ТББ, Германы Хамтын ажиллагааны нийгэмлэг GIZ-тай хамтран ажилладаг.</p> <p>Сэтгэл зүйн зөвлөгөө, сэтгэл зүйн сургалт, төсөл хөтөлбөр хамтран хэрэгжүүлдэг.</p>
ЖАЙКА-тай хамтарсан төсөл, хөтөлбөр	<p>ЖАЙКА болон Хүүхдийг ивээх сангийн хамтран хэрэгжүүлсэн “Хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэх нь” төслийн гүйцэтгэгч байгууллагаар ажиллаж байсан туршлагатай.</p>



Good neighbors ОУБ-тай хамтран тэдний зөвлөгч мэргэжилтэнүүдийг “Зөвлөгөө өгөх ур чадвар”-ын сургалтанд хамруулж гэрчилгээ олгов. Улаанбаатар 2017 он



“Дэлхийн Зөн” ОУБ-тай хамтран “Эцэг, эх байх ухаан” лекцийг үе шаттай зохион байгуулав. Улаанбаатар, Баян-Өлгий аймаг, Завхан аймаг, Хэнтий аймаг 2017 он

Увидас сэтгэл зүйн төв

Байгууллагын нэр	Увидас сэтгэл зүйн төв
Байгуулагдсан он	2003 он
Хаяг	Хан-Уул дүүрэг, 1-р хороо, 15 байр 4 тоот
Утасны дугаар	95863958
E-mail	uvdiscenter@gmail.com
URL/Facebook	Ariunaa Uvdis
Төлөөлөгчийн нэр	И.Ариунаа
Үйл ажиллагааны товч танилцуулга	<p>Зорилго: Ард иргэд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд сэтгэлзүйн иж бүрэн үйлчилгээ үзүүлэх замаар тэдний амьдралын чанарт нөлөөлөх.</p> <p>Хийгдэх үйл ажиллагаа:</p> <ol style="list-style-type: none"> 1. сэтгэлзүйн зөвөлгөө, сэтгэл засал, сэтгэц оношлогоо хийх 2. хөдөлмөр эрхлэлтийг дэмжих 3. нийгмийн олон талт асуудлаар сургалт семинар зохион байгуулах. Үүнд : <ul style="list-style-type: none"> А. Сэтгэлзүйн боловсрол Б. Эрүүл мэндийн боловсрол В. Хөгжмийн боловсрол Г. Бизнес эрхлэх боловсрол гэх мэт 4. дэмжих групп ажиллуулах <p>Тус төв байгуулагдсан цагаас хойш Монгол улсын Эрүүл мэндийн яам, Байгаль хамгаалах яам, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, Хөдөлмөр халамж үйлчилгээний газар, Оюу-Толгой компани, Дэлхийн байгаль хамгаалах сан гэх мэт байгууллагуултай гэрээлэн ажиллаж ирсэн.</p>
Япон болон олон улсын хамтын ажиллагаа	Байхгүй
ЖАЙКА-тай хамтарсан төсөл, хөтөлбөр	Байхгүй



Ивээл цогц хөгжил төв

Байгууллагын нэр	Ивээл цогц хөгжил төв ТББ
Байгуулагдсан он	2014 он
Хаяг	Сонгино Хайрхан Дүүрэг, 31-р хороо, Хайрхан 5
Утасны дугаар	89985394, 99777261
E-mail	dmdora_7@yahoo.com
URL/Facebook	Holistic Blessing Development NGO
Төлөөлөгчийн нэр	
Үйл ажиллагааны товч танилцуулга	Хувь хүний хөгжлийн сургалт явуулан 2, Сэтгэл зүйн зөвөлгөө өгөх, сургалт зохион байгуулна 3, Судалгаа, сургалтын хөтөлбөр боловсруулна 4, Төсөл хөтөлбөр хэрэгжүүлэнэ 5, Хүүхэд, өсвөр үе, эцэг эхчүүдэд зориулсан сургалт хөтөлбөр явуулна 6, Хөгжлийн бэрхшээлтэй гишүүний асран халамжилагчдад зориулсан сургалт хөтөлбөр явуулж, зөвөлгөө өгнө
Япон болон олон улсын хамтын ажиллагаа	Байхгүй
ЖАЙКА-тай хамтарсан төсөл, хөтөлбөр	Байхгүй





Ивээл Цогц Хөгжил Төв ТББ VIP сэтгэл зүйн зөвлөгөө

Сэтгэл зүйч Б.Доржпалам

WELCOME

Манай хамт олон таньд найрсаг
халуун дулаан, тав тухтай
уур амьсгалыг
бүрдүүлэн үйлчилнэ



ОНЦЛОГ



Сэтгэлийн гүнд удаан хугацаанд байсан эмзэглэж явдаг зүйлээс тань хөнгөлж сэтгэлийн амар тайван олоход тань гүүр болох болно

Юунаас болоод яагаад байгаагаа ойлгохгүй байгаа энэ үед тань сэтгэлийн гүн депресс орохдоос тань урьдчилан сэргийлж, оношлон таньд тохирсон сургалтыг боловрсуулан хүргэх болно

Аливаа зүйлсийг бодитойгоор, эрүүл ухаанаар харж зөв чиглүүлэхэд туслана

№	ТУРШАГА
+	Удирдах ажил хийдэг хүмүүсд бизнесээ удирдахад нь зөвлөн гэр бүлийн харилцаа болон хувийн асуудалыг нь шийдэх гарцыг зөвлөсөн
+	Дотны хүнээ алдсан эмэгтэйд гашуудлаа тайлан сэтгэлийн гүн хямралд орохоос урьдчилан сэргийлж сэтгэл зүйн оношлогоо хийж зөвлөгөө өгсөн
+	Онцгой байдлын ерөнхий газрын 25-45 насны залуу гэр бүлүүдэд гэр бүлийн асуудлаа Хэрхэн шийдэх вэ" сургалтыг захиалгын дагуу хийсэн
+	Хүүхдийн насны онцлог, харилцах харилцаа, сурган хүмүүжүүлэх сургалт зөвлөгөө Хүүхдийн 9-12, 13-16 гэх мэт насанд нь тохирсон зөвлөгөө, сургалтууд зохион байгуулдаг
+	Ховд аймгийн 10 жилийн сургуулийн хамт олны захиалгаар "45-65 насны гэр бүлийн харилцааг сэргээх нь" сэдэвт вакумжуулсан сургалт явуулан, зөвлөгөө өгсөн
+	Хүний нөөц ба маркетинг менежментийн зөвлөгөө өгсөн
+	Хувь хүний өөрийгөө үнэлэх үнэлэмж, бусадтай харилцах харилцаа, өөрийгөө бусдад илэрхийлэх чадварт дадлагажуулна
+	Гэр бүл ба хосын харилцаа
+	Хувь хүний хөгжил ба англи хэлний хосолсон сургалт явуулж байсан

Холбогдох утас: 89985394

Facebook page: Hollistic Blessing Development Center NGO

Монголын гэр бүлийн сайн сайхны нийгэмлэг

Байгууллагын нэр	Монголын гэр бүлийн сайн сайхны нийгэмлэг
Байгуулагдсан он	1994 он
Хаяг	Чингэлтэй дүүрэг, 3-р хороо, Пийс тауэр, 909 тоот
Утасны дугаар	70183514
E-mail	info@mfwа.mn
URL/Facebook	www.mfwа.mn. https://www.facebook.com/mfwа.mn
Төлөөлөгчийн нэр	Б. Мөнхцэцэг
Үйл ажиллагааны товч танилцуулга	<p>Монголын Гэр бүлийн сайн сайхны нийгэмлэг (МГБССН) нь 1994 онд байгуулагдсан, аймаг, сумын түвшинд нийт 15 салбар, өсвөр үе, залуучуудын 10 төв, эмэгтэйчүүдийн эмнэлэг, сайн дурын гишүүд, сайн дурын идэвхтэнүүд, залуучуудаараа дамжуулан хүн амд бэлгийн ба нөхөн үржихүйн эрүүл мэнд, (БНҮЭМ) эрхийн талаарх боловсрол, мэдлэг олгох, тусламж, үйлчилгээ үзүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг, ашгийн бус, шашны бус, улс төрийн бус, нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага юм.</p> <p>Үйл ажиллагааны үндсэн чиглэл:</p> <ol style="list-style-type: none"> 1, БНҮЭМ ба эрхийн боловсрол олгох, тусламж үйлчилгээ үзүүлэх бодлого, эрх зүйн дэмжлэгт орчин бүрдүүлэх 2, Өсвөр үе, залуучуудад Бэлгийн болон Нөхөн үржихүйн эрүүл мэнд ба эрхийн мэдээлэл авч, мэдлэг, ур чадвар эзэмшүүлэх 3, Бэлгийн болон Нөхөн үржихүйн эрүүл мэндийн чанартай, цогц тусламж үйлчилгээ үзүүлэх 4, Сайн дурын идэвхитэн, гишүүд, дэмжигчиддээ тулгуурласан, чадварлаг хүний нөөцтэй, хариуцлагатай, нэгдмэл байгууллага байна.
Япон болон олон улсын хамтын ажиллагаа	<ol style="list-style-type: none"> 1, Олон Улсын Гэр Бүл Төлөвлөлтийн Холбоо (IPPF)-ны жинхэнэ гишүүн нийгэмлэг 2, Гэр бүл төлөвлөлтийн асуудлаархи Япон улсын хамтын ажиллагааны байгууллага (JOICFP)-аас унадаг дугуй хандиваар хүлээн авч хөдөө орон нутаг, алслагдсан багийн хүн ам болон эмзэг бүлгийн хүмүүст түгээж ажиллаж байсан. 3, БНХАУ, Казакстан улсын Гэр бүл төлөвлөлтийн нийгэмлэг, Тайланд улсын хүн ам хөгжлийн нийгэмлэг, олон улсын жирэмслэхээс хамгаалах сан зэрэг байгууллагуудтай хамтын ажиллагааны гэрээ байгуулан ажиллаж байсан.
ЖАЙКА-тай хамтарсан төсөл, хөтөлбөр	Хамтран хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй ба 2010 оноос өмнө нийгэмлэгийн 4 ажилтан ЖАЙКА-гийн шугамаар Япон улсад богино хугацааны сургалтанд хамрагдаж байсан.



Монголын радиологийн нийгэмлэг

Байгууллагын нэр	Монголын радиологийн нийгэмлэг
Байгуулагдсан он	1995 он
Хаяг	Шуудангийн хайрцаг -34, Салбар -48, Улаанбаатар -13374
Утасны дугаар	99063486
E-mail	mongolia.radiology@gmail.com
URL/Facebook	https://www.facebook.com/The-Mongolian-Society-of-Radiology-100715675687736
Төлөөлөгчийн нэр	Ерөнхийлөгч Д.Гончигсүрэн
Үйл ажиллагааны товч танилцуулга	<p>Монголын Радиологийн Нийгэмлэг 21 салбартай, 500 гаруй гишүүдтэйгээр үйл ажиллагаагаа явуулдаг.</p> <p>Радиологийн эмч нарын мэргэжлийн зэргийн шалгалт болон Резидентын төгсөлтийн дараахи шалгалтыг бие даан авч, эмч нарын мэргэжил олгох, дээшлүүлэх бүх сургалтанд манай эрдэмтэн багш нар манлайлан оролцож байна.</p> <p>Манай салбар нийгэмлэгийн нэг болох Монголын радиологийн технологичдын нийгэмлэгийн үйл ажиллагаа өргөжиж, Дүрс оношилгооны тоног төхөөрөмжийн тоо, хангамж нэмэгдэж байгаатай холбоотой Радиологийн технологичдын хэрэгцээ, тэдний мэдлэг боловсролыг дээшлүүлэх шаардлага улам нэмэгдэж байна.</p> <p>Үйл ажиллагааны чиглэл:</p> <ul style="list-style-type: none"> • Дүрс оношилгооны сургалт, судалгаа • Монголын Радиологи сэтгүүл • Гишүүдийг хөгжил • Эмнэлгийн мэргэжилтнүүдийн төгсөлтийн дараах сургалт • Олон улсын нийгэмлэгүүдтэй хамтарсан сургалт, хэлэлцүүлэг
Япон болон олон улсын хамтын ажиллагаа	<p>Хамтран ажилладаг олон улсын нийгэмлэгүүд</p> <ul style="list-style-type: none"> • Asian Oceanian Society of Radiology • Japanese Society of Radiology • Korean Society of Radiology • Radiology Across Borders • Бусад олон улсын нийгэмлэгүүд <p>Хамтын ажиллагааны чиглэл:</p> <ul style="list-style-type: none"> • Сургалт • Хамтарсан хэлэлцүүлэг • Хамтарсан судалгаа
ЖАЙКА-тай хамтарсан төсөл, хөтөлбөр	Байхгүй



Зураг 1. Ковидын дүрс оношилгоо сэдэвт цахим сургалтын сургагч багш нар



Зураг 2. Монголын дүрс оношилгооны эмч нарын үндэсний чуулган



Зураг 3. Солонгос-Монголын радиологийн нийгэмлэгийн хамтарсан хурал

Хоол зүй, шим судлалын Монголын нийгэмлэг

Байгууллагын нэр	Хоол зүй, шим судлалын Монголын нийгэмлэг
Байгуулагдсан он	2007 он
Хаяг	Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, GB төв, 201 тоот
Утасны дугаар	99123635, 99844021
E-mail	rem145e@must.edu.mn
URL/Facebook	https://www.facebook.com/MongolianNutritionSociety https://www.facebook.com/groups/1963398450647759
Төлөөлөгчийн нэр	Г.Энхтайван, доктор, дэд проф
Үйл ажиллагааны товч танилцуулга	<p>Тус нийгэмлэг нь бусад олон орны адил Хоолзүйн асуудлаар ажилладаг мэргэжлийн төрийн бус байгууллага бөгөөд хүн амын эрүүл мэндийн үндэс болох хоол шим тэжээлийн байдал, хүнсний хангамж, аюулгүй байдлын талаар мэргэжлийн нөлөөлөл үзүүлэх, зөвлөн туслах, төр, засгийн бодлогод дэмжлэг үзүүлэн, хамтран ажиллахын зэрэгцээ хэрэгжүүлэх, сургалт, эрдэм шинжилгээ, мэдээлэл, зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулах, гадаад, дотоод харилцаа хөгжүүлэх замаар гишүүдийнхээ үйл ажиллагаа, идэвхи санаачлагыг дэмжин ажилладаг.</p> <p>Нийгэмлэг хоолзүйн чиглэлийн олон талт ажил хэрэгжүүлдэг боловч гол чиглэлд цэцэрлэг, сургуулийн хүүхдийн хоолны чанар, шим тэжээлийг сайжруулах, хүний нөөцийг чадавхижуулах чиглэлд ажиллаж байна. Монгол улсад ЕБС-ийн хоол үйлдвэрлэл үйлчилгээний тухайд хуулийг санаачлан, батлуулах чиглэлээр ажилласан.</p>
Япон болон олон улсын хамтын ажиллагаа	<p>Дэлхийн хоолзүйн шинжлэх ухааны нэгдсэн холбоо (IUNS) болон Азийн холбооны гишүүн байгууллага болно. Нийгэмлэгийн үүсгэн байгуулагч, Тэргүүн Профессор Г.Энхтайван төлөөлөл (adhering body) болж ажилладаг. (холбогдох линкийн хавсаргав)</p> <p>https://iuns.org/adhering-bodies/ https://iuns.org/organisations/mongolia/ https://fans-nutrition.asia/fans-members/</p> <p>The Japanese Society of Nutrition and Dietetics, British Nutrition Society, Chinese Nutrition Society, Korean Nutrition Society ТББ-тай хамтран ажилладаг, сүүлийн 5 жилийн MOU байгуулсан.</p> <p>IUNS, FANS мэргэжлийн хамтын ажиллагаатай байгууллагыг үйл ажиллагааг дэмжин ажилладаг, 4 жил тутмын их хурлууд болон бусад хурал, зөвлөгөөн, вебинарт тогтмол оролцдог.</p>
ЖАЙКА-тай хамтарсан төсөл, хөтөлбөр	Байхгүй



KNS and MNS the ceremony of MOU



Prof G.Enkhtaivan and Prof Philip Calder, President of British Nutrition Society, 2017

Монголын урлагийн сэтгэл заслын мэргэжлийн холбоо

Байгууллагын нэр	Монголын урлагийн сэтгэл заслын мэргэжлийн холбоо
Байгуулагдсан он	2017 он
Хаяг	Баянзүрх дүүрэг, 13-р хороолол, Арслантай гүүр, Оюутны хотхон, 40А -5
Утасны дугаар	99122858
E-mail	Bereearththerapy@gmail.com
URL/Facebook	Mongolian Professional Art Therapy Association
Төлөөлөгчийн нэр	В.Бэрцэцэг
Үйл ажиллагааны товч танилцуулга	<p>Манай байгууллага 2017 оноос хойш тасралтгүй үйл ажиллагаагаа явуулсаар байна.</p> <p>2017-2022 оны 3 сар хүртэл хийгдсэн сургалт үйл ажиллагаанд хамрагдсан хүн, цагийг дурдвал;</p> <p>Арт терапи анхан шатны аргазүй олгох сургалт - 724 хүнд 576 цаг, Үе тэнгийнхний дээрэлхэлт, хүчирхийллийг зогсоох, урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт, нөлөөллийн ажил- 1695 хүүхэд 254 цаг; 1949 багш, 174 цаг; 1378 эцэг эх, 147 цаг; Олон нийтэд мэдээлэл өгөх, цахим уулзалт, хэлэлцүүлэгүүд- 80000 гаруй хүнд хүрсэн</p> <p>Арт терапи хөтөлбөрүүд – 511 хүнд, 285 цаг; Бусад сургалтууд (Харилцаа, хандлага ёс зүй) – 150 хүн, 22 цагийн сургалтад тус тус хамрагдсан байна.</p> <p>Одоо хэрэгжиж буй төсөл хөтөлбөр, үйл ажиллагаанаас дурдвал:</p> <ul style="list-style-type: none"> • Арт терапи анхан шатны аргазүй олгох сургалт • Бага насны хүүхдүүдийн нийгэм – сэтгэлзүйн харилцааны ур чадварыг сайжруулах “Тусч банхар” хөтөлбөр • Үе тэнгийнхний дээрэлхэлт, хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалтыг зогсоох, хамгаалах, хариу үйлчилгээ үзүүлэхэд хүүхэд, эцэг эх, багш нарын хамтын ажиллагааг сайжруулах БАНХАР АРТ ТЕРАПИ төсөл • Бага болон өсвөр насны хүүхэд зориулсан “Мөрөөдлийн жигүүр арт терапи хөтөлбөр • Стресс бууруулах арт терапи хөтөлбөр • Байгууллага хамт олонд зөвлөх үйлчилгээ • Хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга сургалт
Япон болон олон улсын хамтын ажиллагаа	UNICEF, НҮБ-ын Хүүхдийн сан, UNFPA, НҮБ-ын Хүн амын сан World Vision – Дэлхийн Зөн ОУБ
ЖАЙКА-тай хамтарсан төсөл, хөтөлбөр	ЖАЙКА-тай хамтарсан төсөл, хөтөлбөр байхгүй.



Монголын мэдээгүйжүүлэгч эмч нарын нийгэмлэг

Байгууллагын нэр	Монголын мэдээгүйжүүлэгч эмч нарын нийгэмлэг
Байгуулагдсан он	2002 он
Хаяг	Чингэлтэй дүүрэг ,4-р хороо, бага тойруу Зоос гоёл байр 306 тоот
Утасны дугаар	88081072
E-mail	khurelochirt@gmail.com
URL/Facebook	Mongolian Anaesthesia Group
Төлөөлөгчийн нэр	
Үйл ажиллагааны товч танилцуулга	Монголын мэдээгүйжүүлэгч эмч нарын эрх ашгийг хамгаалах сайн дурын төрийн бус байгууллага бөгөөд мэргэжлийн чиглэлээр сургалт зохион байгуулах, мэргэжил дээшлүүлэх, зэрэг олгох үйл ажиллагаа явуулдаг.
Япон болон олон улсын хамтын ажиллагаа	Дэлхийн мэдээгүйжүүлэгч эмч нарын холбооны гишүүн.
ЖАЙКА-тай хамтарсан төсөл, хөтөлбөр	Одоогоор хамтаран төсөл хөтөлбөр байхгүй.



Орбис ОУБ-н Монгол дахь салбар төлөөлөгчийн газар

Байгууллагын нэр	Орбис ОУБ-н Монгол дахь салбар төлөөлөгчийн газар
Байгуулагдсан он	2021 он
Хаяг	Сүхбаатар дүүрэг, 3-р хороо, 5-р хороолол, Төгөлдөр Оффис, 4 давхар
Утасны дугаар	99186985
E-mail	Chimgee.chuluunkhuu@orbis.org
URL/Facebook	
Төлөөлөгчийн нэр	Ч.Чимгээ
Үйл ажиллагааны товч танилцуулга	Эрүүл мэндийн байгууллагуудтэй хамтран хүүхдийн болон насанд хүрэгчдийн нүдний тусламж үйлчилгээг сайжруулах төсөл хөтөлбөр хэрэгжүүлдэг. Төслийн хүрээнд эмч болон эмнэлгийн мэргэжилтнийг сургах, эмнэлгүүдийг тоног төхөөрөмжөөр хангах, нүдний тусламж үйлчилгээний тогтолцоог сайжруулах үйл ажиллагаа явуулдаг.
Япон болон олон улсын хамтын ажиллагаа	Япон улстай одоогоор хамтын ажиллагаа байхгүй байгаа. Орбисын төв нь АНУ-н Нью Йорк хотод байдаг ба Орбис ОУБ-н төсөл хэрэгжүүлэгч орнуудтай хамтын ажиллагаатай.
ЖАЙКА-тай хамтарсан төсөл, хөтөлбөр	ЖАЙКА-тай хамтарсан төсөл байхгүй гэхдээ Эрүүл Мэндийн Хөгжлийн Төв дээр төгсөлтийн дараах төсөл дээр ажиллаж байгаа ЖАЙКА багтай уулзаж сувилагчийн сургалтын талаар хамтарч ажиллах талаар ярилцсан.



Монголын сувилагчдын нийгэмлэг

Байгууллагын нэр	Монголын сувилагчдын нийгэмлэг
Байгуулагдсан он	1996 он
Хаяг	Баянзүрх дүүрэг, Энхтайваны өргөн чөлөө -49
Утасны дугаар	99263317, 95221001, 91910830
E-mail	Nyamsuranmna@gmail.com , urnaa0830mna@yahoo.com
URL/Facebook	Монголын Сувилагчдын Нийгэмлэг
Төлөөлөгчийн нэр	Д.Нямсүрэн -Тэргүүн
Үйл ажиллагааны товч танилцуулга	<p>1996 оноос өнөөг хүртэл 25 жил тасралтгүй үйл ажиллагаагаа явуулж ирсэн анхны ууган нийгэмлэг юм.</p> <p>1997 оны 10 дугаар сарын 25 нд Монгол улсын Хууль зүйн яаманд төрийн бус, гишүүддээ үйлчлэх байгууллагын 1008978 тоот регистерээр бүртгүүлэн 23 тоот гэрчилгээ авснаар хуулийн этгээд болж үйл ажиллагаагаа эхэлсэн.</p> <p>Монголын Сувилагчдын Нийгэмлэг нь /МСН/ 72 салбар нийгэмлэг, 9500 гаруй гишүүдийг эгнээндээ нэгтгэсэн тэдний нийтлэг эрх ашгийг хамгаалах сувилагчдынхаа мэдлэг, боловсрол, ур чадварыг дээшлүүлэх, эрдэм шинжилгээ судалгааны ажил болон бүтээлч үйл ажиллагааг дэмжих нийгмийн эрүүл мэндийг хөгжүүлэх зорилготойгоор үйл ажиллагаагаа явуулдаг.</p> <p>2000 оны 05 сарын 26-нд Анхдугаар бага хурлаараа “Сувилагчийн тангараг”, “Сувилагчдын эрхэмлэх ёс зүй”-г батлан гаргасан.</p> <p>2001 онд Швейцарь улсад төвтэй Олон Улсын Сувилагчдын Нийгэмлэгт албан ёсны гишүүнээр элссэн.</p> <ul style="list-style-type: none"> - Үндэсний хэмжээнд 4 жил тутамд их хурал, чуулга уулзалтыг зохион байгуулдаг. - Бага хурлаа 2 жил тутамд зохион байгуулж үйл ажиллагаагаа тодорхойлдог. - Жил бүр ОУСН-ийн уриан дор ОУСӨдрийг 5 сарын 12-нд сувилагчдын дуу хоолойг Засгийн газарт хүргүүлэх, тэдний бүтээлч үйл ажиллагааг дэмжих, сувилагч нараа шагнаж урамшуулдаг. - Олон улсын Сувилахуйн эрдэм шинжилгээний хурлыг жил бүр гадаадын болон дотоодын хамтрагч байгууллагуудтай хамтран зохион байгуулдаг. - Эрүүл мэндийн байгууллагуудынхаа сувилагчдын дунд 2 жил тутам спортын 4 төрөлт тэмцээнийг зохион байгуулж явуулдаг. - Сувилагч нараа алдаршуулах зорилгоор “Сувилагч чамдаа баярлалаа”, “Шилдэг дуучин сувилагч”, “ Сувилагч сайхан бүсгүй”, “Сувилагч миний нүдээр харахад” “Хүн чанар” зэрэг хүндэтгэлийн тоглолт, тэмцээн, уран зургийн уралдаан, дууны клип, баримтат киног хийдэг. - Сувилахуйн “Удирдах ажилтаны зөвлөгөөн”-ийг жил тутам зохион байгуулдаг. - Шинээр төгсөж буй сувилагч нарт “Тангараг өргөх, малгай өмсөх ёслол”-ын үйл ажиллагааг жил бүр хийдэг. - Эрүүл мэндийн яам, Эрүүл мэндийн хөгжлийн төв, ОУ-ын Жайка болон бусад гадаадын болон дотоодын хамтрагч байгууллагатай хамтран 15 сэдвийн хүрээнд сувилагч нарын урт болон богино хугацааны сургалтуудыг танхим, ажлын байранд , цахим, зайн хэлбэрээр зохион байгуулдаг. - Сувилагч нарын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, нийгмийн асуудалд дэмжлэг үзүүлэх зорилгоор сувилагч мэргэшлийн зэргийн шалгалтыг жил бүр зохион байгуулдаг. - Сувилагчдын мэдлэг мэргэжлийг дээшлүүлэх зорилгоор мэргэшлийн зэргийн сорилын эмхэтгэл, гардан ур чадварын гарын авлага, үйлчлүүлэгчдийн биеийн байдлыг үнэлж сувилгааны түүх хөтлөх арга зүй сувилагчийн ширээний ном, гарын эрүүл ахуй, COVID-19 халдварын хяналт ба сэргийлэлт, өвчтний уналт бэртэлтээс сэргийлэх, шинэ сувилагч зэрэг гарын авлага ном, товхимол гарган сувилагч нарын хүртээл болгодог. - “Сувилахуй” сонинг улирал тутамд гаргадаг. - БНСУ, ЯПОН, ХБНГУ, БНХАУ, ОХУ, ТАЙВАНЬ зэрэг орнуудтай хамтын ажиллагааны хүрээнд туршлага солилцох зорилгоор сувилагч нарын мэдлэг мэргэжлийг дээшлүүлдэг.
Япон болон олон улсын хамтын ажиллагаа	<p>“Шинэ сувилагч” гарын авлага, танилцуулгыг гаргаж нийт 35 байгууллагын удирдлага болон сувилагч нарт 10 удаа 800 хүнийг хамруулсан сургалт , семинарыг зохион байгуулсан.</p> <p>Өндөр настны сувилгаа сэдвээр өрхийн эрүүл мэндийн төвүүдийг хамруулсан эмч, сувилагчдын сургалтыг 100 хүнд хийсэн.</p>

	<p>Шинэ сувилагчийг дадлагажуулах нь цуврал сургалтыг 5 удаа 500 хүнд зохион байгуулсан.</p> <p>“Эх нярайд үзүүлэх яаралтай тусламж үйлчилгээ” сэдэвт сургалтыг аймаг орон нутгуудад зохион байгуулсан.</p>
<p>ЖАЙКА-тай хамтарсан төсөл, хөтөлбөр</p>	<p>“Гарын эрүүл ахуй” гарын авлагыг гаргаж эрүүл мэндийн 80 байгууллагуудад тарааж сургалт зохион байгуулсан.</p> <p>“Шинэ сувилагч “гарын авлагыг төрөлжсөн болон дүүргийн эмнэлгүүдэд тараан өгч сургалтуудыг зохион байгуулсан.</p> <p>“COVID-19 халдварын хяналт ба сэргийлэлт” номыг хөдөө орон нутаг, дүүрэг, төв эмнэлгүүдэд хуваарилан өгч нийт 8 удаа сургалт зохион байгуулсан.</p> <p>“Коронавируст халдварын хяналт ба сэргийлэлт” 11 сэдвээр видео кино хийгдсэн.</p> <div style="display: flex; justify-content: space-around; align-items: center;">   </div>



Монгол улсад сувилагчдын анхны мэргэжлийн нийгэмлэг үүсэн байгуулагдсаны 20 жилийн ойн хүндэтгэлийн үйл ажиллагаа СУВИЛАГЧДЫН IV ЧУУЛГАН



ЖАЙКА олон улсын байгууллагын Монгол дахь Төлөөлөгчийн газрын дарга Сато Мүцүми “Сувилахуйн чиглэлээр хэрэгжүүлж буй төслийн хэрэгцээ, үр дүн, цаашдын үйл ажиллагаа” сургалтан дээр

Монголын эх баригчдын холбоо

Байгууллагын нэр	Монголын эх бхригчдын холбоо
Байгуулагдсан он	2006 он
Хаяг	Нийслэлийн Хүрээ амаржих газрын байранд
Утасны дугаар	99165858
E-mail	mongolianmidwivesassociation@gmail.com davaasurenserdamba888@gmail.com
URL/Facebook	Монголын эх баригчдын нийгэмлэг
Төлөөлөгчийн нэр	С.Даваасүрэн, Монголын эх баригчдын нийгэмлэгийн тэргүүн
Үйл ажиллагааны товч танилцуулга	Монголын эх баригчдын нийгэмлэг нь эх баригчдын мэдлэг, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, мэргэжлийн зэрэг хамгаалах, эрдэм судлалын ажлыг өргөжүүлэхэд мэргэжлийн болон удирдлагын арга зүйгээр хангах, тэдний эрх ашгийг хамгаалах, хүн амд үзүүлэх эх барихуйн тусламжийн чанар хүртээмжийг сайжруулах, гэр бүл төлөвлөлт, нийгмийн эрүүл мэндийг хөгжүүлэх, эх баригчдын үйл ажиллагааг идэвхжүүлэхэд хувь нэмэр оруулах зорилгоор үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага билээ. МЭБН нь 21 аймаг, 360 сум, Улаанбаатар хотын 9 дүүрэгт эх баригчдын төлөөлөлтэй, 1000 гаруй гишүүнтэй бие даасан төрийн бус байгууллага юм. Монгол улсад нийт 1067 эх баригч ажиллаж байгаа бөгөөд 39.6 хувь нь сумын эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэгт, 24.4 хувь нь нэгдсэн эмнэлэг, дүүргийн эрүүл мэндийн төв, амаржих газарт, 15.3 хувь нь лавлагаа төвүүдэд эх барихын тусламж үйлчилгээг үзүүлж байна.
Япон болон олон улсын хамтын ажиллагаа	<ul style="list-style-type: none"> • 2010 онд Олон Улсын эх баригчдын нийгэмлэгт албан ёсоор гишүүн орноор элсэж, хамтын ажиллагаатай ажиллаж байна. • Японы эх баригчдын нийгэмлэгтэй 2014 онд холбоо тогтоож, 2015 онд “Twinning” төслийг амжилттай эхлүүлж Монгол улсын эх барихын салбарын тулгамдсан асуудлуудын нэг болж буй жирэмсний таргалалт, том ургийн асуудалд анхаарал хандуулж, “Монгол дахь жирэмсний таргалалтын өнөөгийн байдал” сэдэвт тандалт судалгааг 2017, 2018 онуудад үндэсний хэмжээнд амжилттай зохион байгуулсан. ЯЭБН-ийн удирдлагууд, Кюүшюгийн их сургуулийн доктор, профессоруудтай хамтран дээрхи судалгааны үр дүнг танилцуулах “Жирэмсний үеийн таргалалтаас сэргийлэхэд эх баригчдын оролцоо” сэдэвт сургалт, зөвлөлдөх уулзалтыг 3 жил дараалан зохион байгуулсан. Энэхүү төслийн хүрээнд “Жирэмсний үеийн таргалалтаас сэргийлье” гарын авлага, брошур боловсруулж хэвлэн ЭМБ-дад тараасан. Мөн андройд үйлдлийн системтэй гар утасны “Happy Baby, Healthy Mom” аппликейшн хийсэн. • 2016-2018 онд Франци улсын Сантесюд ТББ-тай “Эх баригчийн ур чадварыг бэхжүүлэх” төсөлд хамтран ажилласан. • 2019 онд ОУ-ын Ротари сан, Япон улсын Гинован Ротари, Ёкохама-Каназава ротари, Монгол улсын Туул Ротари клуб, ЯЭБН-тэй хамтран “Happy birth & Happy baby” төслийг хэрэгжүүлж, төслийн хүрээнд “Нярайн зүрх, уушигны амилуулах тусламж”-ийн үндэсний сургагч багш нарыг бэлтгэж, эх баригч нарт ажлын байрны дадлагажуулах сургалтыг зохион байгуулж ажилласан. Төслийн хүрээнд нийт 110 сургагч багш, давхардсан тоогоор нийт 1450 эх баригчийг “Нярайн зүрх, уушигны амилуулах тусламж”-ийн ур чадвар эзэмшүүлэх сургалтанд хамруулсан. • 2020-2021 онд Япон улсын Токиогийн эх баригчдын танхимтай хамтран Ковидын нөхцөл байдалд Япон-Монголын “Шинэ амьдрал (шинэ хүн)-ыг угтан авах соёл”-ыг дэмжих, Эх баригчдын эх барихуйн тусламж үйлчилгээ ба мэргэжлийн боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн хамтарсан төсөл хэрэгжүүлж байна. Энэхүү төслийн зорилго нь МЭБН ба ЯЭБН-ийн хамтын ажиллагаагаар дамжуулан Монгол, Японы эх барихын тусламж үйлчилгээний бодит байдлыг тусгасан видео контент хийж, тэрхүү видео контент дээрээ суурилсан онлайн хэлэлцүүлэг хийснээр хоёр орны соёлын ялгааг харилцан ойлгох, эх барихын тусламж үйлчилгээний чанарыг дээшлүүлэх, эх баригчид болон эх баригч мэргэжлээр суралцаж буй оюутнуудын боловсролд хувь нэмэр оруулах юм.
ЖАЙКА-тай хамтарсан төсөл, хөтөлбөр	Тус нийгэмлэг нь 2022 оноос Японы Олон Улсын хамтын Ажиллагааны байгууллагын /ЖАЙКА/ “Эмч ба сувилагчийн төгсөлтийн дараах сургалтыг сайжруулах төсөл”-тэй хамтран ажиллахаар шийдэгдсэн бөгөөд төслийн үйл

ажиллагаанд тусгах зорилгоор 2021 оны 12 сарын 16-нд “Эх баригч бидэнд тулгамдаж буй асуудал, эх баригчийн ирээдүйг харах нь” сэдэвт хэлэлцүүлгийг зохион байгуулж ажилласан.



Солонгон хүүхдүүд

Байгууллагын нэр	Солонгон хүүхүүд НҮТББ
Байгуулагдсан он	2021 он
Хаяг	Сүхбаатар дүүрэг, 1-р хороо
Утасны дугаар	99010190
E-mail	Info@rainbow-children.mn
URL/Facebook	www.rainbow-children.mn https://www.facebook.com/MongolianMaternityMark
Төлөөлөгчийн нэр	Очирбат Эрдэнэбулган /Удирдах зөвлөлийн дарга/ Монхдой Баяржаргал /Гүйцэтгэх захирал/
Үйл ажиллагааны товч танилцуулга	СОЛОНГОН ХҮҮХДҮҮД” НҮТББ-ын зорилго нь эх хүүхдийн эрүүл мэндийг дэмжих, тэдэнд ээлтэй нийгмийн орчныг бүрдүүлэхэд хувь нэмрээ оруулах явдал юм. Зорилгодоо хүрэхэд чиглэсэн дараах 2 үндсэн үйл ажиллагааг явуулна. <ol style="list-style-type: none"> 1. Японы “Жирэмсэн эхийн таних тэмдэг”-ийн Монгол хувилбарыг олон нийтэд таниулахад чиглэсэн мэдээлэл, сурталчилгаа, нөлөөллийн ажил зохион байгуулах /Жирэмсэн эхчүүдийн аюулгүй, ая тухтай байдлыг хангахад зориулан бүтээгдсэн “Жирэмсэн эхийн таних тэмдэг” нь суурин соёлд хурдацтай шилжсэн манай нийгэмд эерэг соёлыг бий болгох, нутагшуулахад чухал үүрэг гүйцэтгэнэ гэж найдаж байна/ 2. Жирэмсэн болон хөхүүл эхчүүд, өсвөр насны хүүхдүүдийн сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах, тэдэнд сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх, зөвлөн туслах үйл ажиллагаа явуулах
Япон болон олон улсын хамтын ажиллагаа	Эх хүүхдийн эрүүл мэндийн хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ижил, зорилго чиглэл бүхий байгууллагуудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлэхээр ажиллаж байна.
ЖАЙКА-тай хамтарсан төсөл, хөтөлбөр	2013 онд ЖАЙКА-ын Монгол дахь төлөөлөгчийн газрын Сайн дурынхны хэлтсийн дэмжлэгтэйгээр, АШУҮИС-ын Дархан-Уул аймаг дахь АУС-ын Сувилахуйн тэнхимтэй хамтарч, “Жирэмсэн эхийн таних тэмдэг”-ийн Монгол загварыг батлуулсан юм. Тухайн үед Монголд ажиллаж байсан сувилагч, эх баригч мэргэжилтэй Япон сайн дурын мэргэжилтнүүд хамтран таних тэмдгийг олон нийтэд таниулах ажлыг зохион байгуулахаар төлөвлөж байсан боловч, менежмент, санхүүжилт, цаг хугацааны асуудлаас болоод хэрэгжүүлж амжилгүй үлдээсэн билээ. Тиймээс цаашид “Жирэмсэн эхийн таних тэмдэг”-ийн Монгол хувилбарыг түгээн дэлгэрүүлэхтэй холбогдуулан мэргэжил, арга зүйн дэмжлэг авч хамтран ажиллахаар төлөвлөж байна.



Жирэмсэн эхийн таних тэмдгийн бүтээгдэхүүн хөгжүүлэлт хийгдэж байна



Өрхийн Эрүүл Мэндийн Төвүүдтэй хамтран ажиллаж байна



"Ээжийг минь хайрлаарай" уриан дор таних тэмдгийг олон нийтэд таниулах ажлыг зохион байгуулж байна

ЖИРЭМСЭН ЭХИЙН ТАНИХ ТЭМДЭГ

"Ээжийг минь хайрлаарай" төсөл



ЖИРЭМСЭН ЭХЧҮҮДЭД ЭЭЛТЭЙ АЖЛЫН БАЙР

Ажлын хуваарийг аль болох уян хатан байлгах

Дам тамхидалтанд өртөхөөс сэргийлэх

Ээлтэй, ая тухтай, аюулгүй орчныг бүрдүүлж өгөх

Хортой, хүнд нөхцөлд ажиллуулахгүй байх

ЭЭЛТЭЙ НИЙГМИЙН ТӨЛӨӨ ХАМТДАА

Элэгсэг оршуй

Байгууллагын нэр	Элэгсэг оршуй ТББ
Байгуулагдсан он	2016 он
Хаяг	Баянгол дүүрэг , 10-р хороолол, “Тод Лед” төвийн байр, 1 давхарт
Утасны дугаар	88055545
E-mail	zaya87654@gmail.com
URL/Facebook	Эпилепситэй иргэдийн ТББ
Төлөөлөгчийн нэр	Д.Батзаяа
Үйл ажиллагааны товч танилцуулга	Эпилепси өвчтэй иргэдийн эмийн тогтвортой хэрэглээ, нөхөн сэргээх үйлчилгээ, хөдөлмөр эрхлэлтийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх, өвчтөний гэр бүлүүдийн хооронд туршлага солилцох зорилгоор уулзалт зохион байгуулдаг.
Япон болон олон улсын хамтын ажиллагаа	JICA, JCI, Epilepsy day
ЖАЙКА-тай хамтарсан төсөл, хөтөлбөр	Урьсан үйл ажиллагаануудад тогтмол оролцож байгаа.



Монголын мэргэжилтэн хоорондын хамтын ажиллагааны нийгэмлэг

Байгууллагын нэр	Монголын мэргэжилтэн хоорондын хамтын ажиллагааны нийгэмлэг
Байгуулагдсан он	2021 он
Хаяг	Сүхбаатар дүүрэг, 6-р хороо
Утасны дугаар	77142855
E-mail	Azjargal.b@mnums.edu.mn
URL/Facebook	Mongolian Association of Interprofessional Education & Collaboration Create @Username · Educational Research Center
Төлөөлөгчийн нэр	Б. Азжаргал
Үйл ажиллагааны товч танилцуулга	<p>Мэргэжилтэн хоорондын хамтын ажиллагааны цогц чадамжид сургах, шинэ санаа нэвтрүүлэх, нотолгоонд суурилсан үйл ажиллагааг зохион байгуулах, судалгааны төслүүдийг хэрэгжүүлэх сургалт, судалгааны байгууллага юм.</p> <p>Үйл ажиллагааны үндсэн чиглэл:</p> <ol style="list-style-type: none"> 1. Эмнэлгийн мэргэжилтэн бэлтгэж буй сургуулиудад хөтөлбөрийн талаар чадавхижуулах сургалт зохион байгуулах, нэвтрүүлэх, судалгаа хийх 2. Эрүүл мэндийн байгууллагуудад олон мэргэжлийн багийн сургалт зохион байгуулах, судалгаа хийх 3. АШУУИС-ийн багш, оюутнуудын дунд сургалт зохион байгуулах, судалгаа хийх <p>Хийж гүйцэтгэсэн ажлууд:</p> <ol style="list-style-type: none"> 1. “Оюунлаг залуус” Оюутны эрдэм шинжилгээний хурлыг Nursing & IPT students club –ийн хамт 2 удаа зохион байгуулсан. 2. АШУУИС-ийн оюутнуудад нийт 4 удаагийн сургалтыг зохион байгуулсан. 3. Чиглүүлэгч багш нарын сургалтыг 1 удаа зохион байгуулсан. 4. ОУ-ын сэтгүүлд өгүүлэл 5- ыг хэвлүүлсэн.
Япон болон олон улсын хамтын ажиллагаа	<ol style="list-style-type: none"> 1. Ази, Номхон далайн орнуудын мэргэжил хоорондын хамтын ажиллагааны нийгэмлэг 2. Дэлхийн мэрэгжил хоорондын хамтын ажиллагааны нийгэмлэгтэй тус тус хамтран ажиллаж байна.
ЖАЙКА-тай хамтарсан төсөл, хөтөлбөр	Байхгүй



Ачлалт хүүхдүүд

Байгууллагын нэр	Ачлалт хүүхдүүд
Үүсгэн байгуулагдсан он	2015 он
Хаяг	Сонгино хайрхан дүүрэг, 28-р хороо,Хөтөл 1-5
Утасны дугаар	94114223,94049089
E-mail	achlalthuuhduud@gmail.com
URL/Facebook	Ачлалт хүүхдүүд ТББ
Төлөөлөгчийн нэр	Б.Саранбаатар
Үйл ажиллагааны товч танилцуулга	<p>2015 оны 5 сард хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон ахмад настнуудад чиглэсэн үйл ажиллагаа явуулж, тэдний амьдралын хэв маягийг дээшлүүлэх, нийгмийн оролцоог нэмэгдүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тохиолдож байгаа хүндрэлтэй асуудлуудыг шийдвэрлэх арга замуудыг хайж олоход өөрсдийн хувь нэмрийг оруулах зорилгоор байгуулагдсан.</p> <p>Ачлалт хүүхдүүд ТББ нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон асаргаа шаардлагатай ахмад настнуудад чиглэсэн нийгмийн халамжийн үйлчилгээг сайн дурын үндсэн дээр үзүүлдэг байгууллага.</p> <p>Анхны 2016 оны 4-сард 25 асруулагчид асрамжийн үйлчилгээ үзүүлж эхэлсэн. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Харж хандах хүнгүй, ганц бие, бусдын тусламж дэмжлэг зайлшгүй шаардлагатай ХБИ болон асаргаатай ахмад настнуудын байнгын байрлан амьдрах асрамжийн үйлчилгээг үзүүлж байна. Өнөөдрийн байдлаар энэ үйлчилгээнд 60 ХБИ болон ахмад настан хамрагдаж байна. Бид асрамжийн үйлчилгээнд хамрагдаж байгаа бие даан амьдрах чадваргүй ганц бие иргэдэд хоол, хувцас,эмнэлэг, соёл ахуйн, сэтгэлзүй, асаргаа сувилгаа, хөгжлийн үйлчилгээ үзүүлж тэдний амьдралын хэвийн нөхцлийг бүрдүүлэх, хууль ёсны эрх ашгийг хууль тогтоомжид заасны дагуу хамгаалах үйл ажиллагаа явуулж байна. 2. Ахмад настнууд болон ХБИ-дэд өдрийн үйлчилгээг үзүүлж байна. СХД-ийн нутаг дэвсгэрт амьдарч буй ахмад настнуудын амьдралын идэвхийг нэмэгдүүлэх, чанартай урт наслахад дэмжлэг үзүүлэх зорилгоор дээрх үйлчилгээг үзүүлж байна. Ахмадууд өөрсдийн сонирхолоор нэгдэж, шатар даам, ширээний теннис тоглох, дуулж бүжиглэх, караокедох зэргээр манай төв дээр өдрийг идэвхтэй өнгөрүүлж байна. 3. Шаардлагатай зорилтот бүлгийн иргэд, ХБИ, асаргаа шаардлагатай ахмад настнуудад гэрийн асрамж халамжийн үйлчилгээг үзүүлж байна. Гэртээ дэмжин туслах хүнгүй, зайлшгүй бусдын дэмжлэг хэрэгтэй байгаа ахмад настан болон ХБИ-дэд ус авах, түлээ түлш бэлдэж өгөх, дэлгүүр орж шаардлагатай зүйлийг нь авчирч өгөх, эмчид үзүүлэхэд нь туслах, хувцас хэрэглэлийг нь угаалганд өгөх, шаардлагатай бичиг баримт бүрдүүлэхэд нь туслах, гэрийг нь цэвэрлэх, усанд орохд нь туслах зэргээр гэрээр очиж тусламж үзүүлж байна.
Япон болон олон улсын хамтын ажиллагаа	Байхгүй
ЖАЙКА-тай хамтарсан төсөл, хөтөлбөр	Байхгүй



СХД-ийн 28-р хороо ТББ-ын байр



Асрамжийн газарт ирсэн сайн дурын ажилтнууд асруулагчидын хамт



Асруулагчидын хөгжлийн ажиллагаа / зургийн хичээл /



Асрамжийн төвийн асаргааны ажилчид



Тус төвд өнөөдрийн байдлаар ХБИ болон ахмад настай 60 асруулагч асруулж байна.



Асруулагчдаа тогтмол эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамруулж байна.

Ногоон нуур цэцэрлэгт хүрээлэн

Байгууллагын нэр	“Ногоон нуур цэцэрлэгт хүрээлэн” ТББ
Үүсгэн байгуулагдсан он	2017 он
Хаяг	Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 12 хороо, Булгийн 12 гудамж, 571в
Утасны дугаар	91166366
E-mail	Ulziinuur@gmail.com
URL/Facebook	Ulzii N-nuur
Төлөөлөгчийн нэр	С.Өлзийтогтох
Үйл ажиллагааны товч танилцуулга	<p>Өнөөгийн “Ногоон нуур цэцэрлэгт хүрээлэн” ТББ-ын газараас 1946, 1947 онуудад Японы олзлогдсон цэргүүд Улаанбаатар хотын төв талбай, хотын гол замуудын хайрга чулууг бэлтгэж байсан түүхэн газар юм. 1960 оны эхэн үед их устай болж хаягдсан Чулууны уурхай олон жил эзгүй байж 2012 оны үед хуучин нуур цөөрөм нь ширгэж, хогийн цэг болсон байсан. 2012 оноос иргэн С.Өлзийтогтох өөрийн хөрөнгөөр хогийг цэвэрлэснээр Нуур борооны усаар тэжээгдэн дахин сэргэсэн нь 1000 орчим мод, бут ургуулах усны эх үүсвэр болж өгсөн юм. 2012 оноос хойш жил бүрийн өвөл тэшүүр тоглохоор давхардсан тоогоор 10,000 орчим хүүхэд залуус, зун завь тоглох, амралт чөлөөт цагаа өнгөрүүлэхээр иргэд гэр бүлээрээ ихэвчлэн ирж чөлөө цагаа өнгөрүүлдэг болсон. Өнгөрсөн 10 жилийн хугацаанд 50-70% хямд үнээр иргэдэд үйлчилж ирсэн . Ногоон нуур цэцэрлэгт хүрээлэн нь 2017 оноос Төрийн бус байгууллага болон өргөжиж бага насны хүүхдийн ном, сэтгэхүй хөгжүүлэх тоглоомыг хандиваар цуглуулж өөрийн байшинд ашгийн бус Хүүхэд хөгжлийн үйл ажиллагаа явуулж байна. 1945-1947 онд Монгол улсын нийслэл хотын өнгө төрхийг үндэсээр нь өөрчлөн орчин үеийн хотын эхлэлийг тавьсан Японы олзлогдогсодыг дурсах “Сакура” гэр музейг 2022 оны 8 сарын 4 өдөр нээсэн. Цаашид Музейг өргөжүүлэн хөгжүүлж Түүхийн үнэн байдлыг хүмүүст хүргэхийг зорих юм. Мөн үйл ажиллагаа нэг Японы Төрийн бус байгууллага, иргэдтэй холбоо тогтоон хамтран ажиллах эрмэлзэлтэй байна.</p>
Япон болон олон улсын хамтын ажиллагаа	<ul style="list-style-type: none"> - Европын Соёлын Сангаас санхүүжин “Ногоон баатар” төсөл хэрэгжүүлж европын болон Монгол уран бүтээлчид Хог хаягдалыг ашиглан Урлагийн бүтээл Ногоон нуур цэцэрлэгт хүрээлэнд хийсэн /2021.04 сар/ - АНУ-ын Элчин сайдын яамтай хамтран Америк-Монгол хоёрын орны хооронд дипломат харилцаа үүсгэн байгуулагдсаны 35 жилийн Ойн хүрээнд Америкийн цэргийн Жазз хөгжимчид “Ногоон нуур цэцэрлэгт хүрээлэн“-д тоглолт хийж Орон нутгийн жижиг төсөл хэрэгжүүлсэн - “GerHub” ТББ-тай 2021, 2022 оны 7-8 саруудад Лего тоглоомын хөтөлбөр хэрэгжүүлсэн.
ЖАЙКА-тай хамтарсан төсөл, хөтөлбөр	Үгүй

Монгол улсын төв талбай. 1946 он



Өнөөдрийн Ногоон нуур цэцэрлэгт хүрээлэн. 2010 он



2012 он



2019 он



2022 он

